



# ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2022 – 06 САР | ДУГААР 43

## УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА УНАДАГ ДУГУЙН ХЭРЭГЛЭЭ

Үргэлжлэл 9-р нүүрт

### ГАРЧИГ

- 1-4 Бодлогын нийтлэл
- 5-6 Зохицуулалтын мэдээ
- 7-8 Байр суурь
- 9 Тогтвортой санхүүжилт
- 10-12 Сэндбоксын олон улсын зохицуулалт
- 13-17 Судлаачийн индэр
- 18-19 Санхүүгийн боловсрол /Ногоон даатгал гэж юу вэ?/
- 20 Санхүүгийн тооцоололд суралцъя /хичээл №6/
- 21-22 Компанийн засаглал
- 23-26 Олон улсын зах зээлийн мэдээ
- 27 Олон улсын хөрөнгийн зах индекс

Уншигч танд энэ өдрийн мэндийг хүргэе. Та бүхэнд Хүртээмжтэй санхүү сэтгүүлийн 5 дугаар сарын дугаараар унадаг дугуйн хэрэглээний талаар мэдээлэл хүргэсэн. Энэ сарын дугаараар унадаг дугуй хэрэглэх үеийн санхүүгийн зардлын талаар автомашинтай харьцуулан хүргэхээр бэлтгэлээ.

Санхүүгийн харьцуулалтыг унадаг дугуй худалдан авах, худалдан авсны дараах ашиглалтын зардал болон цаг хугацаа, эрүүл мэндэд үзүүлэх ач холбогдлын талаарх мэдээлэл хүргэе.

Унадаг дугуй нь тээврийн хэрэгслийн хувьд нэг орон зайгаас нөгөө орон зайд таныг хүргэхээс гадна танд дасгал хөдөлгөөн, спортын хэмнэлийг авчирдгаараа эрүүл мэндэд тустай. Номхон далайн баруун бүсийн орнуудад халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тогтоох судалгаагаар 15-64 насны хүн амын дунд хөдөлгөөний идэвхгүй байдал 41-62 хувьтай байгаа нь хүн амын дунд залуужиж байна. Үүнээс урьдчилан сэргийлэх

нэг арга дугуй унаж идэвхтэй хөдөлгөөн хийснээр та эрүүл мэнддээ дараах хөрөнгө оруулалтыг хийх болно.

- 🚲 Тархинд хүчилтөрөгч өгч, стресстэй тэмцэх;
- 🚲 Нурууг чангалж, бэхжүүлэх;
- 🚲 Зүрхний үйл ажиллагааг дэмжих;
- 🚲 Дархлааны системийг сайжруулах;
- 🚲 Үе мөч хүчтэй, тэсвэртэй болох;
- 🚲 Целлюлит арилах;
- 🚲 Нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үр өгөөжөө өгөх.

Мөн байнгын суугаа ажил хийдэг хүмүүс хүчилтөрөгчийн дутагдалд орж, хөдөлгөөн хязгаарлагдсан байдаг бол тэдний хувьд жигд хийх дасгал нь дугуй унах гэж зөвлөсөн байдаг.

Унадаг дугуй унахад эрүүл мэндэд тустай бол та ажилдаа явах, хоол хүнсээ цуглуулах зэрэгт өөрийн тээврийн хэрэгслийн сонголт болгох боломж, давуу болон сул тал юу вэ?

| Унадаг дугуй  | Автомашин   |
|---|---|
| Давуу тал   |   |
| Худалдан авах өртөг бага<br>Шатахуун шаарддаггүй<br>Замын түгжрэлээс хамааралтай бус<br>Хялбар арчилгаа | Тав тухтай<br>Олон хүн зорчих боломжтой<br>Хурдан   |
| Сул тал   |   |
| Бороо, цастай үеэр унахад тухгүй<br>Хот хооронд зорчих боломжгүй  | Шатахууны зардал өндөр<br>Урсгал зардал их гардаг<br>Замын түгжрэлд их цаг зарцуулдаг<br>Арчилгаа ихтэй |






## ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

### ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Байгууллагуудын нийт эрсдэлийг таних, үнэлэх, зохих арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий үйл ажиллагаа.



### RISK MANAGEMENT

A process that aims to help organizations understand, evaluate and take action on all their risks.


Эх сурвалж:  
Банк санхүүгийн тайлбар толь бичиг



## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСӨЛ, САЛБАРЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын  
байгууллагын үйл ажиллагаа эрхэлж  
буй хуулийн этгээдүүд



Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллага / ФАТФ/-ын 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар Монгол Улсыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт буюу саарал жагсаалтад оруулж тодорхой зөвлөмжүүд ирүүлсний нэг нь Монгол Улсын үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй этгээдүүдийг бүртгэлжүүлэх, хянан зохицуулах, салбарын статистик тоон мэдээллийн санг бүрдүүлэх, төрийн бодлого зохицуулалтыг шууд хэрэгжүүлэх үүрэг даалгавар юм.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулж санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ болох үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамааруулан санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхээр хуульчлагдсан. Үүний дагуу 2022 оны 2 дугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос

нийт 280 хуулийн этгээдэд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож, хяналт тавин ажиллаж байна. Эдгээр тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд нь 2022 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 413 хувьцаа эзэмшигч, 296 брокер, 1358 агенттай үйл ажиллагаа эрхэлж байна. Санхүүгийн зохицуулах хороо хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, ФАТФ-аас өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 120 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт бүртгэлийн журам”-ыг батлан, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр дүнд Монгол Улсыг Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллага /ФАТФ/-ын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт буюу “саарал жагсаалт”-аас гаргахаар шийдвэрлэсэн. Тус хуралдаанаар Монгол Улсыг ФАТФ-тай тохирсон ажлын төлөвлөгөөг богино хугацаанд хэрэгжүүлж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоогоо бэхжүүлэх чиглэлээр гаргасан ахиц дэвшлийг онцлон үнэлсэн. Энэхүү үйл явдалд Санхүүгийн зохицуулах хорооны салбарын зохицуулалт чухал нөлөө үзүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хороо нь үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын

байгууллагын үйл ажиллагааг зохицуулж эхэлснээс хойш хоёр жилийн хугацаа өнгөрсөн байна. Өнгөрсөн хугацаанд энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг бүртгэлжүүлж, холбогдох журмуудыг боловсруулан баталж, салбарын зохицуулалтын олон улсын туршлагыг судлах чиглэлд анхааран ажилласан бөгөөд цаашид Монгол Улсад үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн салбарыг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, салбарын оролцогчдын эрх ашгийг хамгаалах, итгэлцлийг бэхжүүлэх, төрийн байгууллагууд болон төрийн бус байгууллага, үл хөдлөх хөрөнгийн зах зээлд оролцогчдын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хяналтын тогтолцоог тодорхой болгож сайжруулах, үл хөдлөх хөрөнгийн менежментийг олон улсын чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг шинэлэг зохицуулалтуудыг хийх практик шаардлага үүссэн.

Үл хөдлөх хөрөнгийн салбар нь эдийн засгийн өсөлт, хүн амын амьжиргааны түвшнээс шууд хамааралтай салбаруудын нэг бөгөөд ДНБ-ий 6.0 орчим хувийг эзэлдэг. Салбарын статистик мэдээнээс үзвэл сүүлийн жилүүдэд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын чиглэлээр ажиллах боловсон хүчний тоо нэмэгдэж байгаа учир энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, чөлөөт өрсөлдөөнийг бий болгох, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн оролцогчдыг чадавхжуулж, мэргэшүүлэх, далд эдийн засгийг ил болгох зэргээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор ажиллаж байна.

Уг ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 9



дүгээр сарын 08–ны өдрийн 363 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”; 2021 оны 4 дүгээр сарын 14–ний өдрийн 152 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тодорхойлох журам”–ыг тус тус баталсан.

Салбарын оновчтой бодлого хэрэгжүүлж, үр дүнтэй хяналт шалгалтыг явуулах замаар үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарын тогтвортой, найдвартай ажиллагааг дэмжих зорилгоор Үл хөдлөх хөрөнгө зуучлалын зохицуулалтын 2021–2024 оны стратеги төлөвлөгөөг боловсрууллаа. Уг стратеги төлөвлөгөөнд технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн хүсэлтийг цахимжуулах, нэгдсэн цахим системд суурь мэдээллийг нэгтгэж, системийн тасралтгүй байдлыг хангах нөхцөлийг, мэргэжлийн холбоог чадавхжуулах гэх мэт зохицуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Мөн улс орнуудын зохицуулалтын туршлагыг судалж Үл хөдлөх хөрөнгө зуучлалын тухай хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төсөлд тусгасан онцлох нэгэн зохицуулалт бол үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санг бий болгох юм. Тус санг бий болгох ажлын хүрээнд Барилга, хот байгуулалтын яамтай 2021 оноос эхлэн хамтран ажиллаж байна. Цаашид санамж бичиг байгуулан ажлыг үр дүнтэй байлгахад анхаарч ажиллана. Ингэснээр мэдээллийн сангаар дамжуулан үл хөдлөх хөрөнгийн салбарын хөрөнгө оруулалтын гарал үүсэл тодорхой болгох, далд эдийн засгийг ил болгох, төрийн байгууллагуудын ажил давхцахгүй хоорондоо харилцан уялдаа, цаг хугацаа болон хөрөнгө мөнгөний хувьд хэмнэлттэй байх гэх мэт олон давуу талтай. Тиймээс салбарын нэгдсэн мэдээллийн сантай болох, тус санг төр удирдах зэрэг зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

Түүнчлэн мэргэжлийн оролцогчдыг мэргэшүүлэх, тэдгээрийн ёс зүйн стандартыг тодорхойлох, мэргэжлийг индексжүүлэх хүрээнд үл хөдлөх хөрөнгийн зуучлалын салбарын мэргэжилтний эрх олгох сургалтыг Санхүүгийн зохицуулах хороо үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгчдийн дээвэр нэгдсэн холбоотой хамтран 2022 онд 2 удаа зохион байгуулж, салбарын 150 мэргэжилтэн хамрагдлаа. Цаашид ёс зүйн стандартыг тодорхойлох, мэргэжлийг индексжүүлэх талаар анхаарч ажиллахаар төлөвлөж байна.



## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Санхүүгийн зохицуулах хорооноос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх зүйн зохистой орчныг бүрдүүлж, Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага /ФАТФ/, олон улсын стандартад нийцүүлэх, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарт мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалаар боловсруулж, урьдчилсан үр дүнг энэ сарын 03-ны өдөр танилцуулсан. Мөн 6 дугаар сарын 04-ний өдөр “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарын эрсдэлийн үнэлгээ, холбогдох журам, зааврыг таниулах” хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, тэдгээрийн холбоод, NFT маркетплейсүүд, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн алба зэрэг холбогдох төрийн байгууллагуудын төлөөлөл бүхий нийт 85 этгээд оролцсон юм.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үндэсний эрсдэлийн үнэлгээг дунджаас дээгүүр гэж үнэлсэн бөгөөд хэлэлцүүлгээр салбарын эмзэг байдлыг 10 хувьсагч, аюул заналын төвшинг 22 хувьсагч, эрсдэлийг бууруулах арга хэмжээг 14 хувьсагчаар тус тус үнэлснийг ажлын хэсгийн төлөөлөл танилцуулж, эрсдэлд нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар мэдээлэл өгч, хэлэлцүүлэв. Мөн цаашид виртуал хөрөнгийн салбарын эмзэг байдал, аюул заналын төвшин, эрсдэлийг бууруулах чиглэлээр Санхүүгийн

зохицуулах хорооноос баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх байр суурийг танилцуулсан. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд заасан шилжилтийн үеийн зохицуулалт энэ сарын 26-ны өдөр дуусгавар болж, Санхүүгийн зохицуулах хорооноос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгэх ажиллагаа эхэлж буйтай холбоотойгоор “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам”, “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-ыг танилцуулж, бүртгүүлэхэд анхаарах асуудлаар мэдээлэл өглөө. Түүнчлэн Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газраас виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагаанд анхаарах асуудал, виртуал хөрөнгийн салбарт гаалийн болон орлогын албан татвар ногдуулалттай холбоотой мэдээлэл өгч, санал солилцсон юм.



Холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт орж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид мэдээлэх үүрэгтэй этгээдэд хамаарагдаж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргийг хүлээсэнтэй холбоотойгоор Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албанаас “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах журмын төслийг танилцуулж, хэлэлцүүлэв. Цаашид виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарын зохицуулалтын оновчтой бодлогыг тодорхойлох, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, инновацыг дэмжиж, эрсдэлээс урьдчилсан сэргийлсэн тогтвортой экосистемийг бий болгоход төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэх нь чухал гэдэг байр суурь дээр нийт оролцогч санал нэгдсэн юм.

## ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АЖИЛЛАЖ БАЙНА

Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэх явцад эрсдэлд орж, эрүүл мэндээрээ хохирч үлдэх тохиолдол цөөнгүй. Тухайлбал, мэс заслын эмч, сувилагчдын нүдний салст руу хагалгааны явцад цусны дусал үсрэх, мэс заслын бохир багажид хатгагдах зэргээс болж элэгний В, С вирусийн халдвар авах цаашлаад элэгний хатуурал, хавдраар өвдөх эрсдэлтэй байдаг. Иймд эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн эрсдэлийн даатгалын асуудлыг хөндсөн “Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн даатгалын хэрэгцээ, шаардлага” сэдэвт хэлэлцүүлгийг энэ сарын 03-ны өдөр зохион байгууллаа. Мөн энэ үеэр хариуцлагын даатгалын тухайд эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх явцад үйлчлүүлэгчид хохирол учруулсан тохиолдолд тухайн хохирлыг даатгалаас нөхөн төлүүлж, шүүх, хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэхээс илүү эвлэрлийн журмаар шийдвэрлэдэг олон улсын сайн туршлагуудыг судалж, эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнд учрах сэтгэл зүйн болон санхүүгийн дарамтыг багасгаж, үйлчлүүлэгчид учирсан хохирлыг чирэгдэлгүй нөхөн төлөх талаар ярилцсан юм.



Түүнчлэн даатгалын тогтолцоог үр дүнтэй болгоход даатгалын хураамжийн хэмжээ эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад санхүүгийн дарамт учруулахгүй байх, байгууллагаас тодорхой хувийг даадаг байх, даатгалаас олгох нөхөн төлбөр нь түргэн, шуурхай олгогдож, эмчилгээний зардалд хүрэхүйц байх, эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээний стандарт, эрсдэлийн менежментийг дэмжих тал дээр анхаарч, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх шаардлагатай талаар санал солилцлоо. Хэлэлцүүлгийн үр дүнд эрүүл мэндийн салбарын болон санхүү, даатгалын салбарын төлөөллийг оролцуулан эмч, сувилагч, эрүүл мэндийн салбарынханд ээлтэй хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын дэд хэсгийг байгуулж, эрүүл мэндийн салбарынхнаар нээлттэй хэлэлцүүлж, санал авах ажлыг зохион байгуулахаар тогтлоо.

## ҮНДЭСНИЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн байгууллагуудын хамтран баталсан шийдвэрийн хүрээнд нэр бүхий байгууллагууд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарт мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкаас 2022 оны 02 дугаар сард гаргасан аргачлалын дагуу боловсруулаад байна.



Үүнтэй холбоотойгоор эрсдэлийн үнэлгээний урьдчилсан хэлэлцүүлгийг 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдөр виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, тэдгээрийн мэргэжлийн холбоод, NFT маркетплейсүүд, виртуал хөрөнгө олон нийтэд санал болгосон этгээд, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Монголбанк, Цагдаагийн ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн алба зэрэг холбогдох төрийн байгууллагуудын төлөөлөл зэрэг 80 гаруй этгээдийг хамруулж, зохион байгуулав. Энэхүү хэлэлцүүлгээр ажлын хэсгийн гишүүд виртуал хөрөнгийн салбарын аюул занал, эмзэг байдал, эрсдэлийг бууруулахтай холбоотой арга хэмжээний үнэлгээний урьдчилсан үр дүнг оролцогчдод урьдчилсан байдлаар танилцуулан нээлттэй хэлэлцэв.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарт мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хэрэгжүүлснээр өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх, чиг хандлага, цаашдын бодлогыг тодорхойлох, эрсдэлийг бууруулах арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх, салбарын хөгжлийг боловсронгуй болгох давуу талуудтай.



Сэндбоксын зөвлөлийн хуралдааныг 2021 онд 2 удаа зохион байгуулж, туршилтад оруулах 3 хүсэлтийг дүгнэлтийн дагуу хэлэлцсэнээс хоёр хүсэлтийг шийдвэрлэж, нэгийг нь түдгэлзүүлсэн. Одоогийн байдлаар технологид суурилсан 2 бүтээгдэхүүн, үйлчилгээ сэндбоксын орчинд амжилттай туршигдаж байна. Тухайлбал, “Мобифинанс” ХХК-ийн дижитал бондын арилжаа нь сэндбоксын орчинд туршигдсан анхны бүтээгдэхүүн бөгөөд 145 хөрөнгө оруулагчаас 1.0 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн. Харин “Мони маркет фонд ҮЦК” ХХК нь 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 02 дугаар шийдвэрийн дагуу сэндбоксын орчинд цахим платформор дамжуулан ББСБ-уудын хооронд репо хэлцлийн арилжааг зохион байгуулж эхэлсэн. 2022 оны 01 дүгээр сард нийт 5 удаагийн арилжаагаар 1.83 тэрбум төгрөгийн хэлцэл хийгээд байна. Ийнхүү зохицуулагч байгууллагын хяналт дор тодорхой хугацаанд шинээр гарч буй технологийн дэвшлийг ашигласан санхүүгийн үйлчилгээнүүдийг бодит орчинд туршсанаар уг бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрэхэд таниулж, мөн хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалж, тохиромжтой зохицуулалтыг боловсруулах боломжтой.

Сэндбоксын орчинд хүсэлт хүлээн авах, бүтээгдэхүүн, үйлчилгээг турших дүгнэлт гарган Зөвлөлд хүргүүлэх, хяналт шалгалт хийх Сэндбоксын нэгжийн чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хорооноос ажлын хэсэг байгуулагдан гүйцэтгэж байсан. Гэвч цаашид сэндбоксын орчинд туршилт хийх эрхзүйн орчин, дэд бүтцийг сайжруулахад бүрэн хариуцаж ажиллах чиг үүрэгтэй нэгж шаардлагатай болсон тул Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 207 дугаар тогтоолоор Сэндбоксын алба байгуулагдаад байна.

**Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын шинэ бүтээгдэхүүн ямар шалгуурыг хангасан тохиолдолд сэндбоксад бүтээгдэхүүнээ турших боломжтой вэ? Сэндбоксад бүтээгдэхүүн, үйлчилгээг ямар хугацаанд туршдаг вэ?**

Сэндбоксад оролцогч нь Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх бөгөөд санал болгох бүтээгдэхүүн нь зах зээлд шинээр нэвтэрч байгаа эсвэл ижил бүтээгдэхүүнүүдээс үр ашиг, өрсөлдөх чадварын хувьд илүү, шат дамжлага зардал багатай санхүүгийн үйлчилгээний хүртээмж болон хэрэглэгчдийн үр өгөөжийг нэмэгдэхэд чиглэсэн байх шаардлагатай. Мөн хэрэглэгчийн мэдээллийн нууцлалыг хангах, программ хангамж нь CISA сертификатын дагуу гүйцэтгэсэн аудитын тайланг эсвэл ISO27001 стандарт хангасан байх шаардлагыг тавьдаг. Сэндбоксын орчинд

оролцогчийн болон бүтээгдэхүүний шаардлагуудтай Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудсанд байршуулсан “Сэндбоксын зохицуулалтын орчны журам”-аас илүү дэлгэрэнгүй танилцах боломжтой.

Сэндбоксын журмын хүрээнд сэндбоксад оролцогч нь 1 жилийн хугацаанд сэндбоксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ туршдаг ба оролцогчийн хүсэлтэд үндэслэн дахин 1 жилээр сунгах боломжтой. Хэрэв оролцогч сэндбоксын туршилтад орох үед тохиролцсон хууль, эрх зүйн хязгаарлалтыг зөрчсөн, буруу ташаа мэдээлэл өгч, мэдээллийг нууцалсан нөхцөлд зохицуулагч байгууллагын шийдвэрээр эсвэл оролцогчийн хүсэлтээр хугацаанаас нь өмнө сэндбокс орчноос гаргахаар тус журамд тусгасан.

**“Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ын хэрэгжилтийг сайжруулах, эрчимжүүлэх зорилгоор Сэндбоксын алба байгуулсан тухай та дээр дурдлаа. Тэгвэл Сэндбоксын алба байгуулагдсанаараа цаашид ямар ажил хийхээр төлөвлөж байна вэ?**

Сэндбоксын алба нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Тухайлбал,

1. Эрх зүйн зохицуулалтыг сайжруулах ажлын хүрээнд Сэндбокс зохицуулалтын орчны журмыг шинэчлэн батлуулах;
2. Сэндбоксын орчинд орох хүсэлт болон холбогдох санал, гомдлыг цахимаар хүлээн авах платформ (<http://license.frc.mn/>) нэвтрүүлэх;
3. Сэндбоксын орчинд орж буй бүтээгдэхүүнийг үнэлэх үнэлгээний арга, аргачлалыг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх;
4. Сэндбоксын орчинд туршигдаж буй бүтээгдэхүүн үйлчилгээг зайнаас хянах рэгтекийг нэвтрүүлэх;
5. Бусад орны сэндбокс зохицуулалтын орчны талаар олон улсын туршлагыг судлах, зөвлөмж, санал боловсруулах зэрэг болно.

Одоогийн байдлаар сэндбокс орчны талаар олон улсад гарч буй шинэ туршилт, сайжруулалтын талаар судалж, мэдээллийн сан үүсгээд байна.

## ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

### УНАДАГ ДУГУЙН ХЭРЭГЛЭЭ БА ЗАРДАЛ, ҮР АШГИЙН ШИНЖИЛГЭЭ

Өмнөх нь 1-р нүүрт

Унадаг дугуй унаснаар автомашинтай харьцуулахад худалдан авах үеийн болон засварын бага хэмжээний зардал шаарддаг бол автомашин нь худалдан авах өртөг, шатахууны зардал, засварын зардал гээд 20.0 саяас 300.0 сая төгрөгийн зардал шаардах өртөг өндөртэй тээврийн хэрэгсэл юм.

| Зардлын төрлүүд           | Унадаг дугуй                 | Автомашин                                 |
|---------------------------|------------------------------|---|
| Худалдан авах үнэ         | 600.0 мянга – 4.5 сая төгрөг | 16.0 сая – 300.0 сая                      |
| Түлш, шатахуун /100 км-т/ | -                            | 600.0 – 1.7 сая (хэрэглээнд зориулагдсан) |
| Засвар, үйлчилгээ         | -                            | 3.0 сая – 10.0 сая                        |

Автомашин оронд унадаг дугуй сонгосноор хэмнэгдсэн хөрөнгөөр та юу хийж болох вэ?

- Хуримтлал нэмэгдэнэ.
- Амьдрах орон сууцаа том талбайтайгаар солино.
- Боловсролдоо хөрөнгө оруулалт хийх боломж нэмэгдэнэ.
- Аялалд явна.



Байгаль орчинд ээлтэй байдлын үзүүлэлтээр Европын холбооноос хийсэн судалгаагаар Европын улс орнуудад нүүрсхүчлийн хийн ялгаруулалтын 60 хувь нь суудлын автомашинаас гардаг байна. Унадаг дугуй нь байгаль орчинд ээлтэй тээврийн хэрэгсэлд тооцогддог ба даатгалын компаниуд ногоон даатгалын бүтээгдэхүүнээр дамжуулан даатгуулагчдынхаа унадаг дугуй болон явган явсан алхмыг аппликейшнээр дамжуулан хэмжиж, түүний урамшууллыг автомашины даатгалын хураамжаас хөнгөлж урамшуулал олгодог.

Унадаг дугуйн хэрэглээ олон улсын түвшинд Ковид-19-ийн дараа хөл хорио болон эрүүл мэндийн шаардлагаар нэмэгдэж байна. Түүнчлэн нийгмийн хүчин зүйл талаас хүмүүс дасгал хөдөлгөөн хийх, нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг бууруулахаар унадаг дугуй хэрэглэх хандлага нэмэгдсэн. Ингэснээр унадаг дугуйн зах зээл дэх эрэлт өсөж байна.



Дугуйн зах зээлийн нийлүүлэлтийн хувьд Денмарк, Белги, Итали болон Франц улсууд цахилгаан дугуйн дэд бүтцийг хөгжүүлэхэд анхаарч байна. Түүнчлэн Европын орнуудад мопед хэлбэрийн дугуй эрэлттэй байгаа бөгөөд тансаг хэрэглээний, эрүүл мэндэд тустай гэсэн тодотголыг хадгалдаг. Харин дугуйн нийлүүлэлтийн дийлэнхийг Азийн улс орнууд хангадаг.

Унадаг дугуйн 2022 оны шилдэг 12 брэндэд Cannondale, Diamondback,

Scott, Trek, Bianchi, Tommaso, Schwinn, Giant, Specialized, Vilano, Kestrel, GMC-ууд орсон байна. Унадаг дугуйн уламжлалт болон цахилгаан гэсэн хоёр төрөл байдаг ба тэдгээрийн үнэ 750.0 мянган төгрөгөөс 4.5 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. Мэдээж уг дугуйнуудыг худалдаалдаг онлайн худалдаа руу ороод захиалах боломжтой ба та нэмж тээврийн зардал төлнө. Эдгээр дугуйны төрлүүд дээр нэмээд манай улсын хөрш болох Хятад улсаас орж ирсэн дугуйнууд зах зээлд элбэг байдаг төдийгүй хилийн цаанаас хямд үнээр захиалах боломж нээлттэй.

Унадаг дугуй худалдан авах боломж санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд танд төлөвлөж урьдчилан хуримтлал үүсгэх, зээлээр худалдан авах, эсвэл финтек компаниудтай гэрээ байгуулж хүүгүйгээр төлбөрөө хувааж төлөх гэсэн боломжууд байдаг.



Хуримтлал үүсгэх нөхцөлд та хуримтлалаа 3-6 сарын хугацаатай хадгаламж, бондод байршуулах нь богино хугацааны эрсдэлийг хаах бөгөөд хүртэх өгөөж нь тодорхой байдаг тул тохиромжтой.



Зээлээр худалдан авах нөхцөлд манайд унадаг дугуйн зээлийг ногоон зээлийн ангилалд оруулдаг тул урьдчилгаа төлбөргүй, бага хүүтэйгээр авдаг. Унадаг дугуйн уг зээл нь урьдчилгаа төлбөр төлөхгүйгээр, 5-8 хувийн хүүтэй, 30 сарын хугацаатайгаар 5.0 сая хүртэлх төгрөгийг зээлэх боломжтой. Уг төрлийн зээлийг манайд Төрийн банк, Хаан банк болон Хас банк олгодог. Ногоон зээлийн ангилал дахь дугуйн зээлийг авахын тулд зээл авах хүсэлтээ цахимаар гаргах боломжтой.



Гар утасны аппликейшнээр зээл авах боломж буюу төлбөрөө хүүгүйгээр хувааж төлөх боломжийн хувьд хэд хэдэн финтек компаниуд уг үйлчилгээг санал болгож байна.

Унадаг дугуйн хэрэглээ эрэлт талаасаа нэмэгдэж байгаа бол байгаль орчин, нийгэмд ээлтэй тээврийн хэрэгсэл тул улс орнуудын Засгийн газраас унадаг дугуйн дэд бүтцийг байгуулах, иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, түүнчлэн унадаг дугуй худалдан авах таатай нөхцөлүүдийг бүрдүүлж байна. Манай улсын хувьд унадаг дугуй унах нөхцөлийг бүрдүүлэх бодлогын баримт бичгүүд хийгдэж байна. Түүнчлэн иргэд өөрсдийн хүсэл зоригоор унадаг дугуй унах нь нэмэгдэж байгаа нь сайшаалтай. Нөгөө талаас унадаг дугуйн хөнгөлөлттэй зээл, финтек үйлчилгээ нь унадаг дугуй худалдан авалтыг нэмэгдүүлж байна.

## ФИНТЕК БА РЭГТЕК

### СЭНДБОКСЫН ОЛОН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Технологийн дэвшил хурдацтай хөгжиж буй өнөө үед зардал, цаг хугацааг хэмнэсэн технологийн шийдэл бүхий ухаалаг бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэхийг бүхий л салбарын оролцогчид зорин ажиллаж байна.

Тэр дундаа уламжлалт санхүүгийн салбарт хиймэл оюун ухаан, блокчэйн технологи, финтект суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжсөөр байгаа билээ. Гэвч технологийн шинэчлэл бүрд түүнтэй холбоотой эрх зүйн орчныг өөрчлөх боломж бага бөгөөд нөгөө талаас зах зээлийг хяналтгүйгээр орхиж болохгүй билээ.

Энэхүү асуудлын хамгийн шинэлэг болон ирээдүйтэй шийдлүүдийн нэг нь зохицуулалтын сэндрокс (regulatory sandbox) юм. Улс орнуудын зохицуулах байгууллагууд финтекийн хөгжлийг хаахгүй, гэхдээ Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын зөвлөмжийн дагуу хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтын арга хэрэгслийг хайх болсноор сэндрокс хэмээх ойлголтыг бий болгосон. Зохицуулалтын хүрээ, арга барил, хандлага ийнхүү өөрчлөгдөж байгаагаас гадна олон улсын томоохон байгууллагууд энэ чиглэл рүү онцгойлон анхаарч буйг Дэлхийн банкны судалгаанаас харж болно.

Шинэ эсвэл шинээр гарч ирж буй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь зохицуулалтын бүх шаардлагыг хангахгүй байж болох тул олон улсын санхүүгийн зохицуулагчид финтекийн зохицуулалтын хамгаалагдсан хязгаарлагдмал орчны горимыг шийдэл болгон хэрэгжүүлсэн.

Сэндрокс гэдэг нь шинэ төрлийн бизнесийг зохицуулагч байгууллагын хяналт дор бага хэмжээний цар хүрээг хамарсан бодит орчинд үйл ажиллагаагаа явуулж, бодитоор турших боломжийг олгосон зохицуулалтын орчныг хэлнэ. Дэлхийн банкны 2020 оны 11 дүгээр сарын Сэндроксын зохицуулалтын орчны олон улсын туршлага судалгаагаар сэндроксыг хэрэгжүүлж

буй 57 улс байна. Эдгээрийн 16 улс буюу 28.1 хувь нь өндөр хөгжилтэй орон байгаа бол 41 улс буюу 71.9 хувь нь хөгжиж буй орон байна. Өндөр хөгжилтэй орнууд (АЕ) сэндроксын орчныг бий болгоход анхдагчид байсан ч шинээр гарч ирж буй зах зээл болон хөгжиж буй эдийн засагтай улс орнууд (EMDEs) тийм ч хол хоцрогдоогүй буюу одоогоор Бразил, Болгар, Мексик, Гүрж, Унгар, Энэтхэг гэх орнуудад сэндроксын зохицуулалт нэвтэрсэн байна.

Манай улсын хувьд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн байгууллагууд болох Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпорацийн хамтарсан 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн А-63/64/32/А/27 тоот тушаалаар “Сэндрокс зохицуулалтын орчны журам”-ыг баталснаар сэндроксын эрх зүйн орчин бий болж, санхүүгийн шинэ бүтээгдэхүүнийг аюулгүй орчинд туршдаг улс орны эгнээнд нэгдээд байна. Зарим улс орнууд финтектэй холбоотой нэгээс олон хамгаалагдсан хязгаарлагдмал орчныг бий болгосон ба тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой төрийн байгууллагууд нь хариуцах заалтыг тусгасан байна.

Жишээлбэл зохицуулалтын сэндроксийн туршилтын хугацааг бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хамаараад дунджаар 6–12 сараар тогтоосон байна. Зарим тохиолдолд (БНСУ, Мексик, Ямайка) хоёр хүртэл жилээр туршилтын хугацааг тогтоосон. Туршилтын хугацаа дуусмагц компани нь тухайн бүтээгдэхүүнээ зах зээлд гаргах (холбогдох зөвшөөрлийг олгож, бүртгэгдсэнээр), эсхүл тестээ зогсооно.

2020 оны дэлхийн банкны судалгааны хураангуйг дараах хүснэгтээс харж болно.

| №  | Улс                 | Эдийн засгийн байдал | Сандбоксын төрөл                   | Тестийн хугацаа     | Фирмийн тоо | Хууль эрхзүйн тогтолцоо | Зохицуулагчийн төрөл                                   | Эхэлсэн он |
|----|---------------------|----------------------|------------------------------------|---------------------|-------------|-------------------------|--|------------|
| 1  | Австрали            | Өндөр хөгжилтэй орон | Бүтээгдэхүүн                       | 12–24 сар           | 7           | Нийтийн эрх зүй         | Үнэт цаасны зохицуулагч                                | 2016       |
| 2  | Бахрейн             | Хөгжиж буй орон      | Сэдэвчилсэн, Хил дамнасан          | 9–12 сар            | 11          | Иргэний эрх зүй         | Төв банк   | 2017       |
| 3  | Барбадос            | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн                       | 8 сар               | 1           | Нийтийн эрх зүй         | Төв банк   | 2018       |
| 4  | Бермуда             | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн, Бодлого              | тусгайлан заагаагүй | 2           | Нийтийн эрх зүй         | Төв банк   | 2018       |
| 5  | Бразил              | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн                       | тусгайлан заагаагүй | тодорхойгүй | Иргэний эрх зүй         | Төв банк, Үнэт цаасны зохицуулагч, Сангийн яам         | 2020       |
|    |                     | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн, Бодлого              | 3                   | 18          | Иргэний эрх зүй         | Төв банк   | 2018       |
| 6  | Бруней              | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн                       | 6–24 сар            | 5           | Нийтийн эрх зүй         | төв банк   | 2017       |
| 7  | Болгар              | Өндөр хөгжилтэй орон | –                                  | хэлбэлздэг          | тодорхойгүй | Иргэний эрх зүй         | Сангийн яам  | 2020       |
| 8  | Канад               | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн, Бодлого              | тусгайлан заагаагүй | 10          | Нийтийн эрх зүй         | Үнэт цаасны зохицуулагч                                | 2017       |
| 9  | БНХАУ               | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн, Бодлого              | тусгайлан заагаагүй | 6           | Иргэний эрх зүй         | Төв банк   | 2019       |
| 10 | Колумб              | Өндөр хөгжилтэй орон | Бүтээгдэхүүн, Бодлого              | 6–8 сар             | 6           | Иргэний эрх зүй         | Санхүүгийн Зохицуулах Хороо                            | 2019       |
| 11 | Дани                | Хөгжиж буй орон      | –                                  | тусгайлан заагаагүй | тодорхойгүй | Иргэний эрх зүй         | Санхүүгийн Зохицуулах Хороо                            | 2019       |
| 12 | Египт               | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн, Бодлого              | тусгайлан заагаагүй | тодорхойгүй | Иргэний эрх зүй         | Төв банк   | 2019       |
| 13 | Эсватинийн вант улс | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн, Бодлого              | 12 сар хүртэл       | тодорхойгүй | Холимог                 | Төв банк   | 2019       |
| 14 | Фижи                | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн, Бодлого              | хэлбэлздэг          | тодорхойгүй | Нийтийн эрх зүй         | Төв банк   | 2020       |
| 15 | Гүрж                | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн, Бодлого              | хэлбэлздэг          | тодорхойгүй | Нийтийн эрх зүй         | Төв банк   | 2020       |
| 16 | Хонг Конг           | Хөгжиж буй орон      | Бодлого                            | хэлбэлздэг          | 46          | Нийтийн эрх зүй         | Төв банк, Үнэт цаасны зохицуулагч                      | 2016       |
|    |                     | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн                       | хэлбэлздэг          | тодорхойгүй |                         | Бусад төрийн байгууллага                               | 2017       |
| 17 | Унгар               | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн, Бодлого              | тусгайлан заагаагүй | тодорхойгүй | Иргэний эрх зүй         | Төв банк   | 2019       |
| 18 | Энэтхэг             | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн                       | 6 сар               | 33          | Нийтийн эрх зүй         | Бусад төрийн байгууллага                               | 2019       |
|    |                     |                      |                                    | тусгайлан заагаагүй | тодорхойгүй |                         | Үнэт цаасны зохицуулагч                                | 2020       |
|    |                     |                      | Бүтээгдэхүүн, Сэдэвчилсэн          | 6 сар               | тодорхойгүй |                         | Төв банк   | 2019       |
| 19 | Индонез             | Өндөр хөгжилтэй орон | Бүтээгдэхүүн, Бодлого              | 12 сар хүртэл       | 1           | Иргэний эрх зүй         | Finacial   | 2018       |
|    |                     |                      | Сэдэвчилсэн                        | 6 сар               | 34          |                         | Төв банк   | 2017       |
| 20 | Мэн арал            | Хөгжиж буй орон      | Сэдэвчилсэн                        | тусгайлан заагаагүй | тодорхойгүй | Нийтийн эрх зүй         | Бусад төрийн байгууллага                               | 2019       |
| 21 | Ямайка              | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн                       | 24 сар хүртэл       | 4           | Нийтийн эрх зүй         | Төв банк   | 2020       |
| 22 | Япон                | Өндөр хөгжилтэй орон | Сэдэвчилсэн                        | 5 сар               | 12          | Иргэний эрх зүй         | Санхүүгийн зохицуулагчид, Бусад төрийн байгууллага     | 2017       |
| 23 | Иордан              | Хөгжиж буй орон      | Сэдэвчилсэн                        | 12 сар хүртэл       | тодорхойгүй | Холимог                 | Төв банк   | 2018       |
| 24 | Казахстан           | Хөгжиж буй орон      | Хил дамнасан                       | тусгайлан заагаагүй | 22          | Иргэний эрх зүй         | Бусад төрийн байгууллага                               | 2018       |
| 25 | Кени                | Өндөр хөгжилтэй орон | Бүтээгдэхүүн, Бодлого, Сэдэвчилсэн | 12 сар хүртэл       | 3           | Нийтийн эрх зүй         | Securities Regulator                                   | 2019       |
| 26 | БНСУ                | Хөгжиж буй орон      | Бодлого                            | 2 жил               | 36          | Иргэний эрх зүй         | Үнэт цаасны зохицуулагчид, Санхүүгийн Зохицуулах Хороо | 2019       |
| 27 | Кувейт              | Өндөр хөгжилтэй орон | Бүтээгдэхүүн, Бодлого, Сэдэвчилсэн | 12 сар              | тодорхойгүй | Холимог                 | Төв банк   | 2018       |
| 28 | Киргиз              | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн                       | тусгайлан заагаагүй | тодорхойгүй | Нийтийн эрх зүй         | Төв банк   | 2020       |
| 29 | Литва               | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн, Сэдэвчилсэн          | 6–12 сар            | 6           | Иргэний эрх зүй         | Төв банк   | 2018       |
| 30 | Малайз              | Хөгжиж буй орон      | Сэдэвчилсэн                        | тусгайлан заагаагүй | тодорхойгүй | Нийтийн эрх зүй         | Төв банк   | 2016       |
| 31 | Малта               | Өндөр хөгжилтэй орон | –                                  | тусгайлан заагаагүй | тодорхойгүй | Холимог                 | Бусад төрийн байгууллага                               | 2019       |
| 32 | Мавритус            | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн, Бодлого              | тусгайлан заагаагүй | 9           | Холимог                 | Бусад төрийн байгууллага                               | 2018       |
| 33 | Мексик              | Хөгжиж буй орон      | –                                  | 2 жил               | тодорхойгүй | Иргэний эрх зүй         | Төв банк, Үнэт цаасны зохицуулагч, Сангийн яам         | 2019       |

| №  | Улс                   | Эдийн засгийн байдал | Сэндбоксын төрөл          | Тестийн хугацаа     | Фирмийн тоо | Хууль эрхзүйн тогтолцоо | Зохицуулагчийн төрөл  | Эхэлсэн он               |
|----|-----------------------|----------------------|---------------------------|---------------------|-------------|-------------------------|---|--------------------------|
| 34 | Мозамбик              | Хөгжиж буй орон      | Сэдэвчилсэн               | 6 сар               | 5           | Иргэний эрх зүй         | Төв банк, Бусад төрийн байгууллага  | 2018                     |
| 35 | Недерланд             | Хөгжиж буй орон      | Бодлого                   | хэлбэлздэг          | тодорхойгүй | Иргэний эрх зүй         | Төв банк, Санхүүгийн зохицуулагчид  | 2017                     |
| 36 | Нигер                 | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн              | тусгайлан заагаагүй | тодорхойгүй | Холимог                 | Төв банк, Бусад төрийн байгууллага  | 2018                     |
|    |                       |                      | Бүтээгдэхүүн, Бодлого     | тусгайлан заагаагүй | тодорхойгүй |                         | Үнэт цаасны зохицуулагчид   |                          |
| 37 | Норвеги               | Өндөр хөгжилтэй орон | Бүтээгдэхүүн              | тусгайлан заагаагүй | тодорхойгүй | Иргэний эрх зүй         | Сангийн яам   | 2018                     |
| 38 | Пакистан              | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн              | тусгайлан заагаагүй | тодорхойгүй | Иргэний эрх зүй         | Securities Regulator  | 2020                     |
| 39 | Филифин               | Хөгжиж буй орон      | Бодлого                   | хэлбэлздэг          | тодорхойгүй | Иргэний эрх зүй         | Төв банк  | 2001                     |
| 40 | Польш                 | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн              | тусгайлан заагаагүй | 8           | Иргэний эрх зүй         | Санхүүгийн зохицуулагчид  | 2018                     |
| 41 | Орос                  | Өндөр хөгжилтэй орон | Бодлого                   | тусгайлан заагаагүй | 15          | Иргэний эрх зүй         | Төв банк  | 2018                     |
| 42 | Руанда                | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн, Сэдэвчилсэн | 6 сар               | 1           | Иргэний эрх зүй         | Төв банк  | 2018                     |
| 43 | Саудын араб           | Өндөр хөгжилтэй орон | Бүтээгдэхүүн, Бодлого     | 6 сар               | 30          | Шашин                   | Төв банк, Санхүүгийн зохицуулагчид  | 2019                     |
| 44 | Серби                 | Хөгжиж буй орон      | Бодлого                   | тусгайлан заагаагүй | тодорхойгүй | Иргэний эрх зүй         | Төв банк  | 2020                     |
| 45 | Сьерра-Леоне          | Өндөр хөгжилтэй орон | Бүтээгдэхүүн, Сэдэвчилсэн | 12 сар              | 4           | Нийтийн эрх зүй         | Төв банк  | 2018                     |
| 46 | Сингапур              | Өндөр хөгжилтэй орон | Бүтээгдэхүүн              | 9 сар хүртэл        | тодорхойгүй | Нийтийн эрх зүй         | Төв банк  | 2019                     |
|    |                       |                      | Бодлого, Хил дамнасан     | 6 сар               | 3           | Нийтийн эрх зүй         | Төв банк  | 2016                     |
| 47 | Хойд Африк            | Хөгжиж буй орон      | Бодлого, Хил дамнасан     | 6 сар               | тодорхойгүй | Холимог                 | Төв банк, Сангийн яам, Санхүүгийн Зохицуулагчид, Бусад төрийн байгууллага | 2020                     |
| 48 | Спайн                 | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн              | тусгайлан заагаагүй | тодорхойгүй | Иргэний эрх зүй         | Сангийн яам   | 2020                     |
| 49 | Шри Ланка             | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн, Бодлого     | 9 сар               | тодорхойгүй | Холимог                 | Төв банк  | 2020                     |
| 50 | Швейцар               | Өндөр хөгжилтэй орон | Бүтээгдэхүүн, Сэдэвчилсэн | хэлбэлздэг          | тодорхойгүй | Иргэний эрх зүй         | Санхүүгийн Зохицуулагчид, Бусад төрийн байгууллага                        | 2018                     |
| 51 | Тайван                | Өндөр хөгжилтэй орон | Бүтээгдэхүүн              | 12 сар хүртэл       | 6           | Иргэний эрх зүй         | Санхүүгийн Зохицуулагчид  | 2018                     |
| 52 | Тайланд               | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн, Бодлого     | 12 сар хүртэл       | 5           | Холимог                 | Бусад төрийн байгууллага (Даатгалын холбоо)                               | 2017                     |
|    |                       |                      |                           | 6-12 сар            | 6           |                         | Төв банк  | 2020                     |
|    |                       |                      | Бүтээгдэхүүн, Сэдэвчилсэн | 12 сар хүртэл       | 4           |                         | Төв банк  | 2017                     |
|    |                       |                      |                           |                     | 8           |                         | Төв банк  | 2017                     |
|    |                       |                      |                           |                     | 10          |                         | Үнэт цаасны зохицуулагчид   | 2017                     |
| 53 | Тунис                 | Хөгжиж буй орон      | -                         | тусгайлан заагаагүй | тодорхойгүй | Холимог                 | Төв банк  | 2020                     |
| 54 | Турк                  | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн, Сэдэвчилсэн | тусгайлан заагаагүй | тодорхойгүй | Иргэний эрх зүй         | Бусад төрийн байгууллага  | 2019                     |
| 55 | Арабын нэгдсэн эмират | Хөгжиж буй орон      | Бүтээгдэхүүн              | 6-12 сар            | 6           | Нийтийн эрх зүй         | Бусад төрийн байгууллага  | 2017                     |
|    |                       |                      | Бүтээгдэхүүн, Бодлого     | тусгайлан заагаагүй | тодорхойгүй | Нийтийн эрх зүй         |   | 2016                     |
| 56 | Их Британи            | Өндөр хөгжилтэй орон | Бүтээгдэхүүн, Бодлого     | 3-6 сар             | 5           | Нийтийн эрх зүй         | Санхүүгийн зохицуулагчид  | 2016                     |
| 57 | АНУ                   | Өндөр хөгжилтэй орон | Бодлого                   | тусгайлан заагаагүй | тодорхойгүй | Холимог                 | Бусад төрийн байгууллага  | 2018                     |
|    |                       |                      |                           |                     |             |                         |   | Бүтээгдэхүүн             |
|    |                       |                      | тусгайлан заагаагүй       | тодорхойгүй         | тодорхойгүй |                         | Бусад төрийн байгууллага  |                          |
|    |                       |                      |                           |                     | тодорхойгүй |                         | тодорхойгүй   | Бусад төрийн байгууллага |

## СУДЛААЧИЙН ИНДЭР

### САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт Н.Нарантуяа, [parantuya@frc.mn](mailto:parantuya@frc.mn)  
Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын мэргэжилтэн Б.Батцэцэг, [battsetseg\\_b@frc.mn](mailto:battsetseg_b@frc.mn)

#### ХУРААНГУЙ

Санхүүгийн үйлчилгээгээр хөгжил, дэвшлийг удирдан чиглүүлж болдог. Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь эрүүл мэнд, боловсрол, бизнест хөрөнгө оруулах арга замыг хөнгөвчлөн иргэд, аж ахуйн нэгжийг ядууралд өртөхгүй байх эсхүл гэнэтийн үйл явдлаас шалтгаалан ядууралд хүргэж болзошгүй нөхцөл байдлыг хялбарчилж өгдөг.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дэлгэрүүлэхийн тулд хаана, ямар төрлийн санхүүгийн үйлчилгээ дутагдалтай байгааг олж илрүүлэхэд түүнийг хэмжих нь зайлшгүй. Энэхүү судалгаагаар манай улсад хэмжих шаардлагатай санхүүгийн үйлчилгээний хэрэглээ болон чанарын түвшнийг тодорхойлохыг зорьж цогц тоон болон чанарын үзүүлэлтийн жагсаалтыг бэлтгэлээ. Уг хоёр санхүүгийн хүртээмжийн үзүүлэлтийг банк, хөрөнгийн зах зээл, даатгал, бичил санхүүгийн салбар тус бүрээр хэмжиж, үүн дотроо иргэд, бизнес эрхлэгчдийн хувьд ангилсан. Түүнчлэн санхүүгийн хүртээмжийг өргөжүүлэхэд ихээхэн нөлөөлж буй дижитал шилжилтийг хэмжих үзүүлэлтүүдийг ч мөн салбар тус бүрээр, мөн санхүүгийн хүртээмжийн индексийг тооцох загварыг боловсрууллаа.

Судалгааны дүгнэлтээр санхүүгийн хүртээмжийг индексээр харуулах, мөн хэрэглээ ба чанарын үзүүлэлтийг тогтмол хугацаанд тууштай тооцож нөхцөл байдлаа тодорхойлон тухай бүр бодлогын арга хэрэгслийн суурь болгон ашиглах тухай санал гарсан.

#### УДИРТГАЛ

Хэмжиж чадахгүй бол та удирдаж чадахгүй гэсэн үг байдаг шиг Монгол Улсад санхүүгийн хүртээмжийг өргөжүүлэхийн тулд хүртээмжийг ямар түвшинд байгааг тодорхойлох нь зүйтэй. Санхүүгийн зохицуулах хороо нь 2016 оноос эхлэн улирал бүр эрхлэн гаргадаг “Санхүүгийн зах зээлийн тойм”-ын санхүүгийн хүртээмж бүлгээр санхүүгийн байгууллагуудын хэрэглэгчтэй ойр байршсан байдал, бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртсэн байдлыг тооцоолж олон нийтэд мэдээлж ирсэн.

Цаашид санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлчлүүлэгчид ямар давтамжтай хэрэглэж, тэдгээрийн чанар ямар түвшинд байгааг хэмжин тодорхойлсноор хүртээмжийг өргөжүүлэх гарцыг тодорхойлох юм. Иймд Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгээс гаргасан санхүүгийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж бүр хүртэж чадаж байгаа эсэхийг тооцох үзүүлэлтүүдийг голчлон, үүн дээр Дэлхийн банк, Олон улсын валютын сан зэрэг олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмжүүдийг удирдлага болгон тодорхойллоо.

Санхүүгийн хүртээмжийн хэрэглээ ба чанар гэсэн хоёр бүлгийн үзүүлэлтийг тооцохдоо банк, хөрөнгийн зах зээл, даатгал, бичил санхүүгийн салбарын ангилал дотор иргэд, бизнес эрхлэгч, дижитал шилжилт гэсэн гурван төрөлд хэмжсэн болно.

Санхүүгийн үйлчлүүлэгчид ойр байрласан буюу нэвтрэх боломж гэсэн үзүүлэлтийг хангалттай тооцдог гэж үзсэн тул хэрэглээ, чанар гэдэг хоёр бүлгийг тооцох үзүүлэлтийг энэхүү судалгаагаар гаргав. Уг судалгаагаар тодорхойлсон хэмжих үзүүлэлтийг байнгын давтамжтайгаар тооцож Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн байгууллагуудаас хамтран баталсан “Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хэмжихэд ач тустай.

Нэгдүгээр бүлгээр санхүүгийн хүртээмжийг хэмжих шаардлага, ач холбогдлыг, хоёрдугаар бүлгээр санхүүгийн хүртээмжийг тооцож буй өнөөгийн байдал, гуравдугаар бүлгээр санхүүгийн хүртээмжийг тооцох хэрэглээ ба чанарын үзүүлэлтүүд, дөрөвдүгээр бүлгээс индекс тооцох аргачлалыг боловсрууллаа.

## САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ ХЭМЖИХ ШААРДЛАГА, АЧ ХОЛБОГДОЛ

Санхүүгийн хүртээмж гэдэг нь иргэд, аж ахуйн нэгжүүдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн санхүүгийн гүйлгээ, төлбөр тооцоо, хадгаламж, зээл, даатгал зэрэг санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжтэй байдал, тэдгээрийг хариуцлагатай, тогтвортой байдлаар хүргэхийг хэлнэ.

Гүйлгээний данстай байна гэдэг нь санхүүгийн хүртээмжийг өргөжүүлж буй нэг алхам бөгөөд гүйлгээний данстай байснаар иргэд мөнгөө хадгалах, төлбөр тооцоо хийх, хүлээн авах боломжийг нэмэгдүүлдэг. Гүйлгээний данс нь бусад санхүүгийн үйлчилгээнд нэвтрэх чухал гарц болдог тул Дэлхийн банкны “Олон улсын санхүүгийн хүртээмж–2020” нь олон нийтийг дэлхий даяар данстай байх боломжоор хангахад төвлөрч байна.

Санхүүгийн зах зээл хүртээмжтэй байснаар өдөр тутмын амьдралын хэв маягийг хөнгөвчилж, гэр бүл, аж ахуй нэгжүүдэд урт хугацааны зорилгоос эхлээд гэнэтийн зүйлсийг төлөвлөхөд тусалдаг. Данс эзэмшигчдийн хувьд зээл, даатгал зэрэг санхүүгийн бусад үйлчилгээг бизнес эхлэх, бизнесээ өргөжүүлэх, боловсрол эсвэл эрүүл мэнддээ хөрөнгө оруулах, эрсдэлийг удирдах, санхүүгийн хямралыг даван туулах зорилгоор ашигладаг ба энэ нь тэдний амьдралын чанарыг дээшлүүлдэг.

2011 оноос хойш санхүүгийн хүртээмжтэй байдалд томоохон алхмуудыг хийж, дэлхий даяар 1.2 тэрбум насанд хүрсэн иргэн хувийн данстай болсон. Өнөөдрийн байдлаар насанд хүрэгчдийн 69 хувь нь данс эзэмшиж байна.

Нийт хүн амын 80 болон түүнээс дээш хувь нь данс эзэмшдэг улс орнуудын (Хятад, Кени, Энэтхэг, Тайланд) хувьд данс эзэмшигчээс данс хэрэглэгч рүү шилжих нь дараагийн алхам болоод байна. Эдгээр улсууд шинэчлэл, хувийн хэвшлийн инновацад тулгуурлан гар утасны болон тоон холболтын төлбөрийг нэвтрүүлсэн нь зардал багатайгаар данс нээхэд чухал нөлөө үзүүлсэн.

Гэсэн хэдий ч Global Findex–ийн хамгийн сүүлийн үеийн мэдээллээр 1.7 тэрбум хүн буюу ойролцоогоор насанд хүрэгчдийн гуравны нэг нь санхүүгийн үйлчилгээний гадна талд амьдардаг ба

тэдгээрийн тал нь хөдөө орон нутаг дахь ядуу өрхийн эмэгтэйчүүд эсвэл ажилгүйчүүд байдаг.

Хөгжиж буй орнуудад данс өмчлөлийн жендерийн ялгаа 9 хувь хэвээр байгаа нь эмэгтэйчүүдэд санхүүгийн байдлаа хянахад саад учруулдаг. Харин гар утсанд суурилсан данс эзэмшдэг хувь өндөр орнуудад жендерийн тэгш бус байдал бага байдаг нь харагдлаа.

- Санхүүгийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлснээр 2015 онд НҮБ–аас баталсан Тогтвортой хөгжлийн 17 зорилтоос 7–г нь хэрэгжүүлэх давуу талтай;
- G20 нь дэлхий даяар санхүүгийн хүртээмжийг сайжруулахыг зорьж дижитал санхүүгийн хүртээмжийн өндөр түвшний зарчмуудыг хэрэгжүүлэхээ амлалаа;
- Дэлхийн банк нь санхүүгийн хүртээмжээр дамжуулан нэн ядуурлыг бууруулах, хамтын хөгжил дэвшлийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл гэж үзэж байна.

2010 оноос хойш 55 гаруй улс орон санхүүгийн хүртээмжийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн бөгөөд 60 гаруй улс орон санхүүгийн хүртээмжийн үндэсний стратеги боловсруулсан эсвэл боловсруулах шатанд явж байна.

Улс орнууд стратегийн арга барилыг баримтлах, санхүүгийн хүртээмжийн үндэсний стратегийг боловсруулахдаа санхүүгийн зохицуулагч байгууллагууд, харилцаа холбооны газрууд, зах зээлийн өрсөлдөөн, боловсролын яамдтай хамтран ажиллах нь шинэчлэлийн хурд, үр нөлөөг нэмэгдүүлдэг болохыг судалгаагаар нотолсон.

### Санхүүгийн хүртээмжид ахиц дэвшил гаргасан улс орнууд:

1. Бүх нийтийн дижитал бүртгэл болох Энэтхэг болон Aadhaar / JDY дансны өргөн цар хүрээг хамарсан бодлогыг хэрэгжүүлсэн. Үүнд 1.2 тэрбум хүн хамрагдсан;
2. Засгийн газраас үзүүлж буй халамж (Орлого багатай орнуудын насанд хүрэгчдийн 35 хувь нь төрөөс өгөх халамжийн мөнгийг авах зорилгоор анх удаа данс нээлгэж байсан);
3. Гар утасны санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэхийг зөвшөөрсөн (Жишээлбэл, Африкт гар утасны данс өмчлөл 12 хувиас 21 хувь хүртэл өссөн);
4. Санхүүгийн хүртээмжтэй байдлыг сайжруулахын тулд цахим худалдаа болох шинэ бизнес загваруудыг хүлээн зөвшөөрсөн;

5. Санхүүгийн зохицуулагч байгууллагууд, харилцаа холбооны газрууд, зах зээлийн өрсөлдөөн, боловсролын яам зэрэг олон талын оролцогч талуудтай хамтран санхүүгийн хүртээмжийн үндэсний стратегийг боловсруулах стратегийн арга барилыг хэрэгжүүлэх;
6. Хариуцлагатай, тогтвортой санхүүгийн үйлчилгээг дэмжих зорилгоор хэрэглэгчийн эрх, санхүүгийн чадавхад анхаарал хандуулах.

### Санхүүгийн хүртээмжийн ашиг тус, ач холбогдол:

Иргэд, бизнес эрхлэгчид, ЖДҮ эрхлэгчдэд нээлттэй эдийн засагт нэгдмэл байдлаар орох нь ач тустай бөгөөд Засгийн газар, банкнуудад ч мөн өгөөжтэй.

- I. Иргэдийн хувьд хуримтлал үүсгэх, шилжүүлэг хийхэд илүү найдвартай, тохиромжтой арга замыг хайдаг.

Санхүүгийн хүртээмж нь тэтгэвэрт гарах эсхүл гэнэтийн зүйлс тохиолдох, боловсрол, түрээсгэхмэт зардлыг төлөвлөхөд тусалдаг. Санхүүгийн хүртээмж нь орлогыг сайжруулан, хадгаламжийг нэмэгдүүлж улмаар эрүүл мэндийн үйлчилгээ, боловсрол, хоол хүнс, бизнесээ хөгжүүлэх, санхүүгийн эрсдэлийг удирдах зэрэг шаардлагатай зүйлүүдэд хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлж чадна гэдгийг хэд хэдэн судалгаа онцолсон. Дижитал санхүүгийн хүртээмж нь төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга гэх мэт төлбөр илгээх, хүлээн авахад шаардагддаг зардлыг бууруулдаг. Судалгаагаар нийгмийн халамжийг гар утсаараа авах нь хүлээж зогсох, зорчих хугацааг дунджаар 20 цагаар хэмнэсэн гэж гарчээ. Өөрөөр хэлбэл, санхүүгийн хүртээмж нь эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлдэг.

- II. Бизнес эрхлэгчид болон ЖДҮ эрхлэгчид шинэлэг санаа, эрч хүчээр дүүрэн байдаг боловч тэдний хөгжил дэвшилд үйлчилгээ, зах зээл, хөрөнгө мөнгө шаардлагатай байдаг.

Бизнес эрхлэгчид болон ЖДҮ эрхлэгчдийг албан ёсны санхүүгийн салбарт оруулах нь илүү сайн санхүүгийн зах зээл, цаашилбал дэлхийн зах зээлийг бий болгох чухал алхам юм. Энэ нь зах зээл дээр тогтвортой үйл ажиллагаа явуулж буй хүмүүсийг хөрөнгө шаардлагатай байгаа залуу үетэй нь холбож өгдөг. Санхүүгийн үйлчилгээнд хамрагдсанаар бизнес эрхлэгчид, ЖДҮ эрхлэгчид үнэ цэнтэй зөвлөх үйлчилгээний тусламжтайгаар хөрөнгө оруулалт хийх, бизнесээ өргөжүүлэх боломжтой. Энэ нь эргээд тэдэнд бизнесийн илүү сайн шийдвэр гаргах чадварыг олгодог бөгөөд ингэснээр бизнес өргөжиж, ажлын байр нэмэгдэж, эдийн засгийн хөгжил цэцэглэлт сайжирдаг.

- III. Банкнууд илүү том, илүү хүртээмжтэй зах зээлийг хөгжүүлэхийг зорьж байна.

Банкны хувьд өргөн хүрээг хамрах нь чухал бөгөөд бизнес, зах зээлийг нэмэгдүүлэх нь эдийн засгийн олон хэсэгт бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэх явдал юм. Технологи ижил төстэй үйлчилгээ үзүүлдэг тоглогчдын өрсөлдөөнийг хөнгөвчилж байгаа нь үнэн. Шинэ үйлчлүүлэгчдийн сегментэд зориулж брэндийн тэгш байдлыг бий болгон, өмнө нь хүрч чадаагүй болон шинэ үйлчлүүлэгчдэд үнэ цэнтэй, тогтвортой харилцааг бий болгоход тусална.

- IV. Бүх иргэд оролцоотой байж, мөнгөний хурд, эдийн засгийн үйл ажиллагааны хурд нэмэгдэн, дамжуулах механизмууд мөнгөний бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлсэн тохиолдолд Засгийн газарт үр өгөөжтэй байдаг.

Албан бус эдийн засгийн хэмжээг багасгах нь аюулгүй байдал, зохицуулалт, хяналтыг нэмэгдүүлэх замаар санхүүгийн гүйлгээнд ил тод байдлыг бий болгодог. Санхүүгийн хүртээмж, данс өмчлөл нь авлигыг бууруулах, татвараас зайлсхийх явдлыг багасгах, татварыг илүү үр дүнтэй төлөх боломжийг бий болгодог. Уламжлалт бэлэн мөнгөний аргын оронд татвар, тэтгэврийн төлбөрийг дижитал төлбөр рүү шилжүүлснээр захиргааны зардлыг бууруулж, үр ашгийг дээшлүүлнэ.

### САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ ТООЦОЖ БҮЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Манай улсын хувьд Global Findex-ээс 2017 онд гаргасан санхүүгийн хүртээмжийг үнэлэх арилжааны банканд данстай иргэдийн тоогоор Дэлхийн дундаж болон хөгжингүй улс орны дунджаас дээгүүр, харин хадгаламжийн түвшнээр доогуур, зээлийн хэмжээ хэтэрхий өндөр гэж гарсан. Үүнээс санхүүгийн нэвтрэлт өндөр байгаа бол цаашид иргэд, аж ахуйн нэгжүүдийг зөв зохистой санхүүгийн хэрэглээнд дадуулах шаардлагатай онцолъё.

Түүнчлэн “Санхүүгийн зах зээлийн тойм”-оор Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалтын хүрээнд зохицуулалттай этгээдүүдээс төвлөрүүлдэг тоон мэдээллээр санхүүгийн үйлчилгээг хүртэх боломжийг харуулах үзүүлэлтийг тооцох боломжтой байгааг Хүснэгтээс харж болно.

## Хүснэгт. Санхүүгийн үйлчилгээг хүртэх боломж

| Хөрөнгийн зах зээл              | Даатгалын зах зээл     | ББСБ  | ХЗХ  |
|---------------------------------|------------------------|---|--|
| Брокеруудын компаниудын байршил | Байршил                | Байршил   | Байршил  |
| Хувьцааны төвлөрөл              | Төлөөлөгчдийн тоо      | Нэг зээлдэгчид ногдох зээлийн хэмжээ                                    | Нэг гишүүнд ногдож буй дундаж зээл                                     |
| Нээгдсэн дансны тоо             | Даатгалын гэрээний тоо | Харилцагчдын тоо  | Нэг гишүүнд ногдож буй хадгаламжийн дундаж хэмжээ                      |
| -                               | Даатгалын гүнзгийрэлт  | Зээлдэгчдийн тоо  | Зээлдэгч гишүүдийн тоо, зээлийн нийт дүн                               |
|                                 | Даатгалын нягтрал      | 100,000 хүнд болон 1,000 аж ахуйн нэгжид ногдох ББСБ<br>Зээлийн ангилал | 100,000 хүнд болон 1,000 аж ахуйн нэгжид ногдох ХЗХ<br>Зээлийн ангилал |

Эх сурвалж: СЗХ, Санхүүгийн зах зээлийн тойм, 2020 он

Монгол Улсын хувьд Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед арилжааны банкны салбар аймаг, сум, дүүрэг бүрд таран байршиж, харин баруун аймгуудад банкны салбарын оронд хадгаламж, зээлийн хоршоо байршсанаараа санхүүгийн үйлчилгээг хүртэх боломжийг бий болгосон давуу талтай.

Цаашид санхүүгийн үйлчилгээг хэрэглэснээр олон нийтийн аж байдлыг сайжруулах дэвшил рүү шилжихийн тулд санхүүгийн хүртээмжийг хэрэглээ болон чанарын түвшинд тооцох юм.

## ДҮГНЭЛТ, САНАЛ

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 зорилтын 7-д нэгдсэнээр санхүүгийн хүртээмжийг сайжруулах аялал нэгэнт эхэлсэн. Монгол Улсад санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэгчидтэй ойр байршсан, хүртээмжийн байдал хангалттай байгаа бол тухайн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчид ямар давтамжтай хэрэглэж байгаа зэрэг хэрэглээний үзүүлэлт, хэрэглэгчдийн санхүүгийн боловсрол, хүртэж буй үйлчилгээ хэр чанартай байгааг тодорхойлох чанарын үзүүлэлтүүдийг хангалттай тодорхойлж чадахгүй байна. Иймд санхүүгийн хүртээмжийн үзүүлэлтийг тооцох үндсэн гурван үзүүлэлтийн

дагуу хүртээмжийн тоон үзүүлэлтийг тууштай, тогтмол тооцож хянах шаардлагатай.

Индексээр санхүүгийн хүртээмжтэй байдлын давуу, сул талыг тооцох үр өгөөжтэй тул цаашид түүнийг тогтмол тооцдог болох саналтай байна.

Судалгааны ажлын үндсэн хоёр хэсэг болох хэрэглээ, чанарын үзүүлэлтийг тодорхойлох явцад өөр өөр мэдээллийн эх сурвалжаас судалгаанд суурилан эсхүл асуумж хэлбэрээр зэрэг өөр өөр арга барилаар мэдээлэл цуглуулах шаардлага гарсан. Тус ажлыг гүйцэтгэх санхүүжилтийн асуудлаар олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрт хандан санхүүжилт татах боломжийг эрэлхийлж тогтмол хугацаанд хүртээмжийг хэмждэг болох.

Хүртээмжийг хэмжих хэрэглээ ба чанарын тоон үзүүлэлтийг банкнаас бусад санхүүгийн салбарын зохицуулалттай этгээдүүдээс төвлөрүүлэхийн тулд хөрөнгийн зах зээл, даатгал, бичил санхүүгийн зах зээлийн холбогдох журамд нэмэлт өөрчлөлт оруулан баталж, мэдээ цуглуулах дэд бүтцийг хөгжүүлэх.

Хүртээмжийн үзүүлэлтийг давтамжтайгаар тооцож, өнөөгийн нөхцөл байдлаа тодорхойлж, хариу арга хэмжээ авах, олон нийтэд мэдээлэх.

## ЭХ СУРВАЛЖ

1. AFI, *Alliance for financial inclusion policy model: AFI core set of financial inclusion indicators*
2. AFI, *SME financial inclusion indicators base set (SME finance base set, 2013)*
3. AFI, *Mobile Financial Services Indicators for Measuring Access and Usage, August 2013*
4. AFI, *digital financial services indicators, July 2019*
5. IFC, *Financial Inclusion Data Assessing the Landscape and Country-level Target Approaches, October 2011*
6. World bank, *Financial Inclusion*
7. <https://www.worldbank.org/en/topic/financialinclusion/overview#1>
8. World bank, *Hot to measure financial inclusion, February 2015*
9. Center for Financial Inclusion, *Why financial inclusion matter*
10. <https://www.centerforfinancialinclusion.org/why-financial-inclusion-matters>
11. *Global partnership for financial inclusion*
12. <https://www.gpfi.org/sites/gpfi/files/G20%20Set%20of%20Financial%20Inclusion%20Indicators.pdf>

# САНХҮҮГИЙН ЛУЙВРЫН НИЙТЛЭГ ТӨРЛҮҮД БА ТЭДГЭЭРИЙН ШИНЖ



## Понзи схем

### Урьдчилгаа төлбөрт луйвар

- Урьдчилан төлбөр төлөхийг яаруулдаг
- Судлах материал хомс



- Бага эсвэл ямар ч эрсдэлгүй өгөөж амладаг
- Тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулдаг
  - Нууцлагдмал, тодорхой мэдээлэлгүй
  - Хэт тогтмол өгөөжтэй байдаг



### Санхүүгийн пирамид

- Шинээр гишүүн элсүүлэхийг шаарддаг
- Бодит бүтээгдэхүүн, үйлчилгээ борлуулдаггүй
- Богино хугацаанд өндөр өгөөж амладаг



### Сургалтын луйвар

- Биелэхэд хэцүү зүйлийг амархан мэтээр үнэмшүүлдэг
- Өөр газраас үнэгүй олох мэдээллийг өндөр үнээр санал болгодог
- Яаруулж, бодох хугацаа олгодоггүй
- Дараа дараагийн сургалтад илүү өндөр үнээр хамрагдахыг шаарддаг
- Хуурамч мэдээлэл ашиглан сурталчилгаа хийдэг



### Памп & Дамп

- Зохицуулалт багатай зах зээл рүү чиглэдэг
- Богино хугацаанд өндөр өгөөж амладаг
- Зохицуулалт багатай цахим сүлжээгээр мэдээлэл түгээдэг /Telegram, Discord, .../
- Зохиомлоор үнэ цэнээ нэмэгдүүлэхийн тулд цуу яриа, ташаа мэдээлэл тараадаг
- Хүмүүсийн итгэлийг олохын тулд олны танил хүмүүсийг оролцуулдаг



## ШИНЭЭР БИЙ БОЛСОН ЛУЙВРЫН ТӨРЛҮҮД

### “Rug pull”

- Худал койн гарган хөрөнгө оруулагчдын мөнгийг залилдаг
- White paper нь хоёрдмол агуулгатай, эргэлзээ төрүүлэхүйц
- Сурталчилгаа маш ихээр хийдэг
- Өндөр өгөөж амладаг
- Хувьцааны үнэ ихээр хэлбэлздэг



### “Covid-19 scam”

- Цаг үеийн нөхцөл байдал эсвэл вакцины талаар мэдээлэл авахын тулд хувийн болон дансны мэдээллээ бичихийг шаарддаг
- Зах зээлээс хэт хямд үнээр эмчилгээний бүтээгдэхүүн зарахыг санал болгодог
- Дээрх тохиолдолд урьдчилгаа төлбөр шилжүүлэхийг шаарддаг

## ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

## ТҮҮХЭНД БҮРТГЭГДСЭН ХАЧИРХАЛТАЙ САНХҮҮГИЙН ЛУЙВРЫН КЕЙС

САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО



1821 онд Шотланд улсын иргэн болох Генерал Грегор Макгрегор Төв Америкаас Их Британи хүртэл завиар явахдаа **ПОЯИСЫН АРЛЫГ** нээн илрүүлжээ.

Тэрээр арлыг алтны нөөц ихтэй, хөрсний шим сайтай тул жилд 3 удаа ургац хураах боломжтой талаар дуулгахад **ХҮМҮҮС ИХЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙЖ, ОДООГИЙН ХАНШААР 20 САЯ ДОЛЛАР** цугларсан.

**ГЭВЧ ЭНЭ БҮГД ЛУЙВАР БАЙСАН** ба бодит байдал дээр Пояис нэртэй ямар ч арал байгаагүй.



## ТА САНХҮҮГИЙН ЛУЙВАРТ ӨРТӨХ ЭРСДЭЛТЭЙ ЮУ?

Та 2 болон түүнээс дээш асуултад **"ТИЙМ"** гэж хариулсан бол **ТА САНХҮҮГИЙН ЛУЙВАРТ ӨРТӨХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА.**

- 1 Танд бага эсвэл ямар ч эрсдэлгүй өндөр өгөөж амлаж байна уу?
- 2 Таны хөрөнгө оруулах гэж буй салбар төрийн зохицуулалтгүй юу?
- 3 Таныг төлбөрөө төлөхийг яаруулж байна уу?
- 4 Танд асуулт асуух боломж олгож байна уу?  
Таны асуултад оновчтой хариулж байна уу?
- 5 Шагнал, бэлэг авахын тулд урьдчилгаа төлбөр төлөхийг шаардаж байна уу?
- 6 Одоо л ....-д хөрөнгө оруулахгүй бол "Сайхан боломжийг алдана" гэж шууд болон шууд бусаар үнэмшүүлж байна уу?



**ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

## САНХҮҮГИЙН ТООЦООЛОЛД СУРАЛЦЬЯ (ХИЧЭЭЛ №6)



ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА В.ЭНХБААТАР

### АРИФМЕТИК БА ГЕОМЕТР ДУНДАЖ, МЕДИАН, МООД, ЖИГНЭСЭН ДУНДАЖ

#### Арифметик дундаж

Бүлэг тооны тоон утгын дунджийг илэрхийлэх ба тухайн бүлэгт багтах бүх гишүүдийн тоон утгын нийлбэрийг тухайн бүлгийн гишүүдийн тоонд хуваасан ноогдвор юм.

$$\text{Арифметик дундаж} = \frac{\Sigma (\text{тоон утга})}{\text{гишүүдийн тоо}}$$

Тухайлбал, 5, 6, -7, 13, -5, 4, 16 багтаасан бүлэг тооны арифметик дундаж:

$$\frac{(5+6-7+13-5+4+16)}{7} = 4.57$$

#### Медиан дундаж

Бүлэг тооны эрэмбээрээ дундах тоог медиан гэнэ. Дээрх жишээний бүлэг тоог гишүүдийг өсөх дарааллаар эрэмбэлбэл (-7, -5, 4, 5, 6, 13, 16), үүний медиан нь '5' юм. '5' бүлгийн голд байрлах бөгөөд '5' тооноос баруун, зүүн тийш тус бүр гурван тоо байна.

Бүлэг тооны гишүүдийн тоо тэгш бол голын хоёр гишүүний тоон утгын арифметик дундаж нь тухайн бүлгийн 'медиан' байна.

#### Моод

Бүлэг тоонд хамгийн их давтагдах тоог моод гэнэ, бүлэгт нэгээс илүү моод байж болно. Дээрх жишээ бүлэг тоонд '5' хоёр, бусад тоо нэг давтагдсан тул бүлгийн моод '5' болно. (58, 52, 53, 57, 58, 60) бүлэг тооны арифметик дундаж, медиан, моодыг тодорхойлъё.

Арифметик дундаж:

$$\frac{(58+52+53+57+58+60)}{6} = 56.33$$

Медиан: Бүлгийн тоог өсөх байдлаар эрэмбэлбэл (52, 53, 57, 58, 58, 60), бүлгийн медиан нь '57' ба '58' хоёр тооны арифметик дундаж 57.5 байна. Моод '58'.



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### КОМПЛАЙНСЫН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛАВ

Санхүүгийн зохицуулалтын мөн чанар нь хэрэглэгчийн хууль ёсны эрхийг хамгаалахад оршдог. Хамгаалах зохицуулалт нь санхүүгийн хэрэглэгчийн эрх зөрчигдөх тохиолдолд эсрэг хориг арга хэмжээ авдаг ч цар тахлын үед хэрэгжүүлж буй зохицуулалтын арга хэмжээнүүд нь санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг онцгойлон хамгаалсан шинжийг өөртөө агуулдаг.

Тухайн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаа амжилттай явагдаж байгаагаас үл хамааран комплайнсын ажилтнууд өөрсдийн мэргэжлийн ур чадвар, мэдлэгийн хүрээгээ байнга тэлж, санхүүгийн хэрэглэгчийг эрсдэлд оруулж болзошгүй шалгуур үзүүлэлтүүдийг удирдах, хянах шаардлагатай.

**Яагаад үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах нь чухал вэ? Үүнд:**

#### САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШИГ

Аливаа бизнесийн гол цөм нь хэрэглэгчид ба тэдэнгүйгээр бизнес хөгжих боломжгүй. Тиймээс бизнес эрхлэгч болон бүтээгдэхүүн, үйлчилгээ хүртэгчид хоорондын зөв харилцаа маш чухал. Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд борлуулах үйл явц нь хэрэглэгчдээс өндөр итгэлцэл, харин санхүүгийн байгууллагаас хариуцлагатай байдлыг давхар шаарддаг.

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн хувьд хэрэглэгч, үйлчлүүлэгчийн үндсэн хүлээлтийг үргэлж хангадаг байх нь маш чухал үүрэг хариуцлага юм.



## ЗАХ ЗЭЭЛД ИТГЭХ ИТГЭЛ

Хэрэглэгч санхүүгийн гэрээнээс татгалзах хүсэлт гаргах тохиолдолд тухайн санхүүгийн байгууллага хөрөнгийг нь түргэн шуурхай, бүрэн бүтэн буцааж өгнө гэдэгт итгэдэг.

Гэвч зах зээлийн эрсдэлээс шалтгаалан энэхүү хүлээлт бүрэн биелэхэд хүндрэл учрах тохиолдлууд бий. Энэ тохиолдолд эдгээр хүндрэлийг үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчдад сайтар ойлгуулах ёстой ба энэ нь хөрөнгийг нь буцаан өгөх хугацааг хойшлуулах шалтгаан болох ёсгүй.

Нөгөө талаас үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчид гэрээний гуравдагч тал, ханган нийлүүлэгч гэх мэтэй холбоотой аливаа хүндрэлүүд, ялангуяа хөрөнгийн буцаалттай холбоотой бусад бэрхшээлийн талаар ямар ч тайлбар сонсох сонирхол, хүсэлгүй байдаг. Иймд тэдэнд элдэв тайлбаргүйгээр хөрөнгийг нь нэн даруй буцааж өгөх чадамж нь л санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг хадгалах гол хөшүүрэг болж байна.

## УЯН ХАТАН

Бизнес эрхлэгчид өөрсдийн тооцоолж буй хүлээлтээс ангид, гэнэтийн эрсдэлтэй тулгардгийн хамгийн ойрын жишээ гэвэл Ковид-19 цар тахал болон 2008 оны санхүүгийн хямрал зэрэг юм.

Дээр дурдсан дэлхий нийтийг хамарсан гамшиг, хямралтай харьцуулахад бага хэмжээний эрсдэлүүд буюу тухайлбал, компанийн эд хөрөнгө, барилга галд өртөх, бизнес бүтэлгүйтэх, үйл ажиллагаанд доголдол гарах, технологи болон хүний нөөцтэй холбоотой учрах хүндрэлүүд гэх мэт эрсдэлүүд тохиолдож болох авч үйлчлүүлэгчид тэдгээрийн

тухайн бизнест үзүүлэх үр нөлөөг төдийлөн анхаардаггүй.

Учир нь тэд тухайн бизнес нь гэнэтийн нөхцөл байдлыг тэсвэрлэх чадвартай, дотоод зохицуулалт сайтай, тасалдалгүй ажиллах төлөвлөгөөтэй байдаг гэж төсөөлдөг ба ингэснээр санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй гэдэгт итгэдэг, хүлээлттэй байдаг.

Тухайн бизнесийн үйл ажиллагаа “уян хатан байх” гэдэг нь үйлчлүүлэгчдийн зан төлөв, хүлээлтийг үйл ажиллагаандаа нийцүүлэх гэж тодорхойлж бас болох юм.

## ИТГЭЛ ДААХ

Леман Бродерс 2008 онд дампуурлаа зарлах үед үйлчлүүлэгчид хөрөнгөө нэн даруй хохиролгүйгээр буцааж авна гэдэгт итгэсээр байв. Гэвч зарим үйлчлүүлэгчдийн хувьд өөрсдийн хууль ёсны хөрөнгөө авах гэж 10 гаруй жил зарцуулсан байдаг. Эдгээр үйл явдлууд нь зах зээлд оролцогчдын итгэлцэлд сөргөөр нөлөөлж, зах зээлийн хөгжилд маш их хохирол учруулдаг.

Санхүүгийн хэрэглэгчийн болон зах зээлийн хүлээлтэд нийцсэн бизнес эрхлэх нь үйлчлүүлэгчдийнхээ хүлээж буй итгэлийг бий болгох боломжийг олгох тул комплайнсын ажилтан мэдлэг, мэргэжлийн ур чадвараа тогтмол сайжруулж байх хэрэгтэй.

Онцлон хэлэхэд, дэлхий нийт цар тахлаас салж, бизнесүүд үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлж эхлэхтэй зэрэгцэн нэгэнт олж авсан мэдлэгээ сэргээх, шинэчлэхэд одоогоос илүү тохиромжтой цаг үе гэж байхгүй аж.



Эх сурвалж: International Compliance Association

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### УКРАИН ДЭЛХИЙН БАНКНЫ ЗЭЭЛЭЭР ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫНХАА ЦАЛИНГ ТАВИНА.



Украины Дэлхийн банкнаас авах ээлжит зээл 1.49 тэрбум доллароор батлагдсан тухай Reuters агентлаг мэдээлэв. Баталгааг нь Латви, Литва, Их Британи, Нидерланд болон Итали улсууд гаргажээ. Гэтэл Латви, Литва улсууд нь өөрсдөө зээлийн асуудалтай байгаа. Тухайлбал, Литвагийн өр ДНБ-ийх нь 45 хувь, Латвийнх нь 48 хувьтай тэнцэж буй. Дээр дурдагдсан мөнгөөр Украины төрийн албан хаагчид, төсвийн байгууллагын ажилтнуудын цалинг тавина. Энэхүү зээл нь 4.0 тэрбум долларын тусламжийн багцын хэсэг юм. Ер нь 2014 оноос эхлэн Украин Дэлхийн банкнаас 11.0 тэрбум долларын зээл авчээ. Мөн хугацаанд ОУВС Украинд 16.58 тэрбум доллар, Европын банк 3.0 тэрбумыг өгчээ. Урсула фон дер Ляйены хэлснээр, Европын холбоо 2014 оноос хойш 20.0 тэрбум доллароор Украинд тусалжээ.

### ГЕРМАНД АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ХӨЛС 4 ДАХИН НЭМЭГДЖЭЭ.



ХБНГУ-ын өрхийн аж ахуйн үйлчилгээний компаниуд төлбөрөө нэмэхээс өөр аргагүйд хүрсэн тухай Welt агентлаг мэдээлэв.

Уг шийдвэр нь 2022 оны 5 дугаар сарын 11-ны өдрөөс Орос байгалийн хийн нийлүүлэлтээ тасалсантай холбоотой аж. Өнөөдрийн байдлаар, мегаватт-цагийн дундаж үнэ 85.0 евро хүрээд байна. Өмнө нь хэрэглэгчид 20.0 евро төлдөг байжээ. Германы засгийн газар эрчим хүчний шинэ экспортлогч нарыг хайж байгаа ч бүтэл муутай байна. Холбооны засгийн газрынхаа шийдвэртэй Саксонийн ерөнхий сайд Михаэль Кречмер зөрчилдөж Шольцын танхимыг шүүмжлэх болов.

### ЕХ ОРОСЫН ЭСРЭГ ЗУРГАА ДАХЬ БАГЦ ХОРИГ АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛЖЭЭ.

Европын Холбооны /ЕХ/ Зөвлөл Украины байдалтай холбогдуулан ОХУ-ын эсрэг авах зургаа дахь багц хориг арга хэмжээг эцэслэн баталлаа гэж хэвлэлийнхэнд мэдээлжээ.



Шинэ багц хориг арга хэмжээнд ЕХ-ны орнууд ОХУ-ын газрын тосны импортоос зургаан сарын дотор, газрын тосны бүтээгдэхүүний импортоос найман сарын

дотор татгалзах, мөн ОХУ-аас далайгаар нийлүүлдэг газрын тосноос үе шаттайгаар татгалзахаар тусгажээ. Харин хоолойгоор нийлүүлдэг газрын тосыг хоригт оруулаагүй байна. Үүнээс гадна, Оросын телевизийн “Россия-24”, “РТР-Планета”, “ТВ-Центр” сувгуудыг Европт нэвтрүүлэхийг хориглох, Сбербанк, Россельхозбанк, Москвагийн зээлийн банк болон Беларусын Сэргээн босголт, хөгжлийн банкныг SWIFT-ээс хасах, Оросын компаниудад зөвлөх, аудит, PR үйлчилгээ үзүүлэхийг хориглох, үүлэн үйлчилгээнд нэвтрэх эрхийг хязгаарлах зэрэг арга хэмжээ багтжээ. Оросоос далайгаар нийлүүлдэг газрын тос, газрын тосны бүтээгдэхүүнд тавьсан хоригоос Болгар, Хорват улсуудыг түр чөлөөлсөн байна. Хориг арга хэмжээ ЕХ-ны Албан ёсны сэтгүүлд нийтлэгдсэний дараа хэрэгжиж эхэлнэ.

### ДЭМБ: ДЭЛХИЙН ХҮН АМЫН ГУРАВНЫ ХОЁРООС ИЛҮҮ НЬ КОВИД-19-ИЙН ЭСРЭГ БИЕТТЭЙ БОЛСОН.

Дэлхийн хүн амын гуравны хоёроос илүү хувь нь тодорхой хэмжээнд Ковид-19-ийн эсрэг биеттэй болсон байх магадлалтай

хэмээн Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/ мэдэгдэв. Энэ нь дээрх тооны хүмүүс вакцинд хамрагдсан эсвэл халдвар аваад эдгэрсэн гэсэн үг юм.

ДЭМБ-ын дэлхий даяар явуулсан судалгааны дүнгээр, өнгөрсөн 2021 оны 02 дугаар сард цусны шинжилгээ хийсэн хүмүүсийн 16 хувьд нь эсрэг биет илэрч байсан бол өнгөрсөн 2021 оны 10 дугаар сард энэ тоо 67 хувьд хүрсэн байна.

Илүү хурдтай тархдаг омикрон хувилбар гарч ирснээр энэ тоо одоо илүү өндөр болсон байх магадлалтай юм. Мөн өмнө нь вакцин хийлгэсэн ч нэмээд халдвар авсан хүмүүс өвчин хүндрэхээс хамгийн сайн сэргийлж байгаа талаар ихэнх судалгаануудын дүн харуулж байна.

### **В.ЗЕЛЕНСКИЙ: УКРАИНЫ ГАЗАР НУТГИЙН 20 ХУВЬ НЬ ОХУ-Д ЭЗЛЭГДСЭН.**

ОХУ одоогийн байдлаар манай улсын газар нутгийн 20 орчим хувийг эзлээд байна гэж Украины Ерөнхийлөгч Владимир Зеленский 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдөр буюу пүрэв гарагт Люксембургийн парламентад болон ард иргэдэд хандаж үг хэлэхдээ мэдэгджээ.

Тэрээр “Оросын цэргүүд 02 дугаар сарын 24-ний өдрөөс хойш Украины 3620 суурин руу орсон. Тэдгээрээс 1017-г нь чөлөөлж чадсан бол 2603-ыг нь чөлөөлөх шаардлагатай байна” гэж хэлсэн байна.

“Өнөөдрийн байдлаар манай газар нутгийн 20 орчим хувь нь түрэмгийлэн эзэмшигчдийн хяналтад байгаа бөгөөд энэ нь 125 мянга шахам хавтгай дөрвөлжин километр юм” гэж тэрбээр нэмж хэлээд Дайны улмаас 12 сая Украинчууд дотооддоо, хүүхэд, эмэгтэйчүүд голдуу 5 сая гаруй хүн хилийн чанад руу дүрвэсэн гэж Украины Ерөнхийлөгч цохон тэмдэглэсэн байна.

“Хэрэв ОХУ энэ дайнд ялбал, бүх Европын хувьд хар бараан цаг ирнэ. Хэрэв бид энэ дайнд ялбал европчууд эрх чөлөөт амьдралаа үргэлжлүүлж чадна” гэж В.Зеленский мэдэгджээ.

Мөн дайн эхэлснээс хойших 99 хоногийн хугацаанд “хэдэн арван мянган хүн” амь үрэгдсэн тул дайныг зогсооход дэлхий нийтийн дэмжлэгийг хүсэж байна гэжээ.

### **“JP MORGAN”-Ы ТЭРГҮҮН “ЭДИЙН ЗАСГИЙН ХАР САЛХИ” ОЙРТОЖ БАЙГААГ АНХААРУУЛЖЭЭ.**

Дэлхий нийтийг “эдийн засгийн хар шуурга” хүлээж байгаа бөгөөд үүнд бэлдэж эхлэх шаардлагатай гэж Америкийн томоохон банкуудын нэг болох “JP Morgan Chase”-ийн тэргүүн Жейми



Даймон Нью-Йорк хотноо 2022 оны 6 дугаар 01-ний өдөр буюу лхагва гарагт болсон санхүүгийн бага хурлын үеэр мэдэгджээ.

“Бидний дээр шуурганы үүл хуралдаад байна гэж би өмнө нь хэлж байсан, харин одоо хэлснээ өөрчлөхийг хүсэж байна, учир нь бидэн рүү хар салхи ойртож байна” гэж тэрбээр хэлсэн байна.

Хэдийгээр одоо бүх зүйл эмх цэгцтэй байгаа мэт санагдаж байгаа ч ойртож буй гамшиг “жигжиг хуй салхи эсвэл сүйрэл дагуулах “Сэнди” хар салхи” болж хувирах эсэхийг хэн ч мэдэхгүй гэж Даймон тэмдэглээд уулзалтад оролцсон шинжээчид, хөрөнгө оруулагчдад хүндрэл бэрхшээлд бэлтгэхийг зөвлөсөн байна. “Эрсдэлд бэлэн байх нь хамгийн сайн арга. “JPMorgan” бэлдэж эхэлнэ. Манай бодлого балансын тооцоонд маш консерватив байх болно” гэж тэрбээр хэлжээ.

АНУ-ын эдийн засаг 2023 онд уналтад орох магадлал өндөр байгаа талаар “Washington Post” сонин урьд нь мэдээлжээ. “S&P” агентлагийн ахлах эдийн засагч Бет Энн Бовиногийн тооцоолсноор, 2023 онд АНУ-ын эдийн засаг уналтад орох магадлал 35 хувьтай байна гэж сонинд бичсэн байна. Ойрын ирээдүйд тус улс үл хөдлөх хөрөнгийн зах зээл, барилгын салбар асуудалтай тулгарна гэж мэргэжилтнүүд салбарын үзүүлэлтүүдэд үндэслэн таамаглажээ.

АНУ-ын Хөдөлмөрийн яамны мэдээлснээр, 3 дугаар сард тус улсын инфляц сүүлийн 40 жилийн дээд хэмжээнд буюу 8.5 хувьд хүрчээ. 2022 оны 1 дүгээр улиралд АНУ-ын ДНБ жилийн дундаж үзүүлэлтээс 1.4 хувиар буурсан талаарх мэдээллийг тус улсын Худалдааны яам 4 дүгээр сарын сүүлчээр нийтэлсэн байна.

### **ЯПОНЫ АВТОМАШИН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ БУУРЧЭЭ.**

Японы найман томоохон автомашин үйлдвэрлэгчийн дэлхий даяарх нийт үйлдвэрлэл 2022 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 20.1 хувиар буурч, 1.66 саяд хүрснийг 2022 оны 5 дугаар 30-ны өдөр танилцуулсан салбарын мэдээлэл харуулжээ.

Дэлхийн хэмжээнд хагас дамжуулагч хомсдож, Шанхай хотод “COVID-19”-ийн улмаас хөл хорио тогтоосноос үүдэн нийлүүлэлт тасалдсаны үр дагавар үүнээс харагдаж байна.

Тодруулбал, “Toyota”-гийн тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл 9.1 хувиар буурч, 692,259-д хүрсэн нь сүүлийн гурван сарын хугацаанд анх удаа буурсан үзүүлэлт болж, 750 мянган тээврийн хэрэгсэл үйлдвэрлэх зорилтдоо хүрч чадаагүй байна.



“Toyota” болон бусад автомашин үйлдвэрлэгчид хагас дамжуулагч хомсдож байгаагийн улмаас үйлдвэрлэлээ бууруулахаас өөр аргагүйд хүрчээ. Хагас дамжуулагчийг автомашинаас эхлээд агааржуулагч, ухаалаг утас зэрэг олон төрлийн бүтээгдэхүүнд хэрэглэдэг бөгөөд дижиталчлал түргэсэж байгаатай холбоотойгоор эрэлт нь улам нэмэгдэж байгаа юм.

“Honda” компанийн гарцын хувьд Хятадад үйлдвэрлэл нь саатсаны улмаас 54.2 хувиар буурчээ. Мөн “Mazda Motor”, “Nissan Motor” компаниудынх 49.9 хувь, 26.5 хувиар тус тус буурсан байна. Харин “Subaru” компанийн үйлдвэрлэлийн гарц өнгөрсөн сард 63.3 хувиар өссөн нь сүүлийн гурван сарын хугацаанд анхны өсөлт болжээ. Мөн Индонез, Малайзад үйлдвэрлэл нь эрчимжсэнээр “Daihatsu Motor” компанийн гарц 4.1 хувиар өссөн байна.

“Toyota” компанийн мэдээлснээр, 4 дүгээр сард дэлхий даяарх борлуулалт жилийн өмнөхөөс 11.1 хувиар буурч, 763,708-д хүрчээ. Ингэснээр энэ үзүүлэлт найман сарын турш дараалан буурч байна. Тус компанийн Япон дахь борлуулалт нь 16.8 хувиар буурч, 103,143 болсон бол дотоодын үйлдвэрлэлийн гарц 9 хувиар буурч, 243,425 болжээ. Мөн хилийн чанадын борлуулалт нь 10.2 хувиар /660,565/ буурсан бол үйлдвэрлэл нь 9.1 хувиар /448,834/ буурсан байна.

Бүс нутгаар авч үзвэл, “Toyota”-гийн Хятад дахь борлуулалт 30.7 хувиар буурсан бөгөөд үүнд Шанхайд халдварын улмаас хөл хорио тогтоосны дараа эрэлт буурсан нь нөлөөлжээ. Мөн тус улс

дахь үйлдвэрлэлийн гарц 33.8 хувиар буурч, 93,297 тээврийн хэрэгсэл үйлдвэрлэсэн байна.

Мөн Хойд Америкт борлуулалт 4 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 19.7 хувиар буурсан бол үйлдвэрлэл 7.1 хувиар буурчээ. Үүнд эд ангийн хомсдол нөлөөлжээ. “COVID-19” цар тахал, эд ангийн нийлүүлэлтийн байдлаас үзэхэд нөхцөл байдал тодорхойгүй хэвээр байгаа ч бид учрах үр дагаврыг хамгийн бага байлгахын төлөө бүхий л хүчин чадлаа дайчилж байна” гэж “Toyota”-гийн мэдэгдэлд дурджээ.

## ОХУ, МОНГОЛ УЛСЫН ХУДАЛДААНЫ ЭРГЭЛТ 5.0 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРТ ХҮРЭХ БОЛОМЖТОЙ.

Орос, Монголын худалдааны хөгжлийн хурдац 2026 он гэхэд хоёр орны худалдааны эргэлтийн хэмжээг 5.0 тэрбум ам.долларт хүргэх зорилт тавих боломжийг бидэнд олгож байна гэж Монгол дахь ОХУ-ын худалдааны төлөөлөгч Максим Васильев Улаан-Үд хотноо болсон “Орос, Монгол. Шинэ бодит байдал дахь түншлэл” чуулга уулзалтын үеэр мэдэгдсэн байна.

“Манай хоёр улсын худалдаа [цар тахалтай холбоотой хязгаарлалтын дараа] хурдан сэргэх шинжтэй байгаа бөгөөд хангалттай их нөөцтэй, хөгжлийн чухал хөдөлгөгч хүчтэй” гэж М.Васильев онцолжээ.



Тэрбээр мөн хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх гол үүрэг Монгол Улстай түүх, нийгэм, эдийн засгийн талаар гүн гүнзгий холбоотой, өмнө захаар Монголтой хиллэдэг Бүгд Найрамдах Буриад Улсад оногдож байгааг тэмдэглэсэн байна. Үүнээс гадна, хоёр талын худалдааг тэнцвэржүүлэх, чөлөөт худалдаа, банкны харилцан төлбөр тооцоотой холбоотой асуудлыг шийдвэрлэх тал дээр ажиллах нь чухал гэж үзэж байгаагаа илэрхийлжээ.

Чуулга уулзалтад оролцсон Монголын төлөөлөгчдийн тэргүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн мэдэгдэхдээ, хоёр улсын хооронд санхүүгийн харилцааг хөгжүүлэх нь стратегийн ач холбогдолтой

болохыг онцлон тэмдэглэсэн байна. Түүний хэлснээр, Монголын бизнес эрхлэгчид импортолсон бараа бүтээгдэхүүнийхээ төлбөрийг ОХУ руу шилжүүлэхэд хүндрэл бэрхшээлтэй тулгарч байгаа аж. “Манай хоёр улсын хооронд төлбөрийн механизмын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгааг бид харж байна. Бизнесийн таатай үйл ажиллагаа явуулахын тулд бид санхүүгийн асуудлыг нэн тэргүүнд шийдэх шаардлагатай байна” гэж тэмдэглэжээ.

Буриадын тэргүүн Алексей Цыденов түүнтэй санал нийлж байгаагаа илэрхийлээд евро, доллар ашиглахгүйгээр “рубль–төгрөгөөр” буюу үндэсний валютаар харилцан төлбөр тооцоо хийх нь маш чухал гэдгийг цохон тэмдэглэжээ. “Энэ асуудлыг шийдвэл хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа эрс идэвхэжнэ. Оросын талд рубль–төгрөгийн төлбөр тооцоонд шилжих эрмэлзэл байгаа бөгөөд Холбооны улсын түвшний холбогдох бүх удирдагч ийм эрмэлзэлтэй байгааг баталж байгаа гэж тэрбээр хэлсэн байна.

### ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВ.

Оросын эдийн засгийн хөгжлийн дэд сайд Дмитрий Вольвач Монгол Улс бол ОХУ–ын стратегийн маш чухал түнш юм. Сүүлийн үед Орос–Монголын худалдааны эргэлт хоёр оронтой тоогоор нэмэгдэж байгаа бөгөөд 2022 оны эцэс гэхэд 2.0 тэрбум ам.долларын босгыг давна гэж хүлээх бүх үндэслэл бий гэж мэдээлсэн байна.

Монголын уламжлалт экспорт, тэр дундаа арьс шир, ноолууран бүтээгдэхүүн, хивс, түүнчлэн мах, махан бүтээгдэхүүн, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн ОХУ–ын зах зээлд маш ирээдүйтэй. ОХУ ч мөн Монгол руу эрчим хүчний эх үүсвэр, металл, мод, машин механизм, тоног төхөөрөмж, химийн бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтээ нэмэгдүүлэхэд бэлэн байна гэж Д.Вольвач хэлжээ. “Харилцан ашиг сонирхлын хүрээнд Орос–Монгол–Хятадын эдийн засгийн коридор байгуулах, түүнийг эхлүүлэхэд тээвэр, цахилгаан эрчим хүч, аж үйлдвэрийн гаалийн зохицуулалт, байгаль орчны хамгаалал, шинжлэх ухаан, аялал жуулчлалын чиглэлээр 30 гаруй төсөл хэрэгжүүлэх шаардлагатай байна. Монгол Улстай хийж буй худалдаа, эдийн засгийн харилцааг ОХУ–ын 72 бүс нутаг дэмжиж байна” гэж Эдийн засгийн хөгжлийн дэд сайд нэмж хэлэв.

Монгол Улсаас ОХУ–д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ө.Энхтүвшиний хэлснээр, хоёр тал одоогоор стратегийн түншлэлийн бүхий л боломжийг идэвхтэй ашиглаж чадахгүй байна. “Монгол Улсын гадаад худалдааны эргэлтэд ОХУ–ын эзлэх хувь ердөө 12 хувьтай байгаа бол БНХАУ–ынх 60 гаруй хувьтай байна. Бид Сибирь, Алс Дорнодын бүс нутаг руу Монголын уламжлалт мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг илүү ихээр экспортлох хүсэлтэй байна” гэж тэрбээр хэлээд гаалийн өндөр татвар саад бэрхшээл бий болгож байгаа бөгөөд үүнийг оновчтой болгох шаардлагатай байгааг тэмдэглэжээ.

Д.Вольвач хариуд нь Монгол Улс Евроазийн эдийн засгийн холбоонд /ЕАЭХ/ ажиглагч улсын статус авах боломжийг сайтар судалж чадна гэдэгт итгэлтэй байгаагаа мэдэгдэв. Тэрбээр ЕАЭХ болон Монгол Улсын хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахаар төлөвлөж байгааг мэдэгдээд “энэ нь бүх гишүүн оронтой хамтын ажиллагаагаа өргөжүүлэх сайхан боломж” гэдгийг онцолсон байна.

Буриадын тэргүүн хэлэхдээ, Монголын нийслэл Улаанбаатар хот Оросын агаарын тээврийн компаниуд болон иргэдийн агаарын тээврийн зангилаа болох боломжтой гэжээ. “Монгол Улстай агаарын харилцаанаас гадна, авто болон төмөр замын харилцаа шинэ ач холбогдол, шинэ боломжуудыг олгож байна. Учир нь Оросын эдийн засаг одоо Дорно зүг рүү эргэж байгаа тул Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудтай харилцах, түүнчлэн зүүн чиглэлээр дамжуулан бусад улс оронд нэвтрэх нь чухал болоод байна” гэж тэрбээр хэлжээ.


“Орос–Монгол. Шинэ бодит байдал дахь түншлэл” нэртэй чуулга уулзалт 5 сарын 27–28–ны өдрүүдэд ОХУ–ын Буриад улсын Улаан–Үд хотод болсон юм. Чуулга уулзалтын үеэр Монгол, Оросын эдийн засгийн гадаад үйл ажиллагааны зохион байгуулалт, хоёр орны аялал жуулчлалын харилцан солилцоог хөгжүүлэх хэтийн төлөв, тээвэр, ложистикийн харилцааг өргөжүүлэх, эрүүл мэндийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүтээлч чиглэл, хөдөөд аж ахуйн аж үйлдвэрийн цогцолбор дахь түншлэл, боловсрол, барилгын салбарын хамтын ажиллагааны талаар хэлэлцжээ.

## ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2022 оны 05 дугаар сарын 24-ний өдөр

S&P 500 / ^GSPC/


**3,789.99** +54.51 (+1.46%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 / ^N225/


**26,908.60** +582.44 (+2.21%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 / ^FTSE/


**7,273.41** +85.95 (+1.20%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

**11,099.15** +270.81 (+2.50%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

© САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia





Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia